



# **ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ШҮҮХИЙН ТАМГЫН ГАЗАР**



## **2023 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БҮТЭН ЖИЛИЙН ТАЙЛАН**

**2023 он**

**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ШҮҮХИЙН ТАМГЫН ГАЗРЫН  
2023 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

**ГАРЧИГ**

**НЭГ. УДИРТГАЛ**

**ХОЁР. ШҮҮХИЙН БИЕ ДААСАН БАЙДЛЫГ ХАНГАХ ЧИГЛЭЛЭЭР  
ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ**

2.1. Захиргааны удирдлагыг хэрэгжүүлэх, эрх зүйн орчныг боловсронгуй болгох үйл ажиллагаа

2.1.1. Нийт ажилтнуудыг хамруулан нийгэмд тустай, сайн үйлсийн арга хэмжээ зохион байгуулах, энэ талаар шүүхийн цахим сайт, мэдээллийн самбарт болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах

2.1.2. Шүүхийн ерөнхий зөвлөлөөс ирүүлсэн хууль тогтоомж, дүрэм журам, аргачлал, стандартын “Нэгдсэн сан” бүрдүүлэх, тухай бүр шүүгч, ажилтнуудад танилцуулах, судалгаа хийх, үр нөлөөтэй санал өгөх, хагас бүтэн жилээр тайлагнах

2.1.3. Тухайн шүүх, шүүгчдэд мэдээлэл танилцуулж хэвших

2.1.4 Шүүхийн ерөнхий зөвлөлөөс хүргүүлсэн цахим талбарт шүүхийн Тамгын газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг тухай бүр оруулах, явцыг эрх бүхий байгууллагаас баталсан байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний тайлан гаргах журмын дагуу улирал бүр цахим талбарт тайлагнах

2.1.5. Шүүхийн үйл ажиллагааны ил тод байдал, шүүхийн үйлчилгээний талаар олон нийтэд мэдээлэх иргэдэд зориулсан мэдээллийн самбарыг шүүхийн байрны гадна талд ил тод байршуулах, мэдээллийг тогтмол шинэчилж хэвших

2.1.6. Иргэдэд шүүхийн байгууллага, шүүхийн байрыг заасан таних тэмдэг, тэмдэглэгээ, самбарыг шүүхийн байрны ойролцоо нийтийн эзэмшлийн зам, талбай бүхий зохих газарт ил тод байршуулах

2.1.7. “Шүүхийн Тамгын газрын мэдээллийн нэгдсэн сан”-ийн хөтлөлтийг сайжруулах

2.1.8. Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн ач холбогдлын талаар иргэдэд ухуулан таниулах ажлыг хэрэгжүүлэх, олон нийтэд сурталчлах

2.1.9. Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн нэрсийн нэгдсэн жагсаалт бүрдүүлэх ажлыг зохион байгуулах

2.1.10. Шүүхийн иргэдийн төлөөлөгчөөр оролцохын ач холбогдлын талаар иргэдэд ухуулан таниулах ажлыг хэрэгжүүлэх, олон нийтэд сурталчлах

2.1.11. ERP Системийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх

2.2.1. Төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны нэгдсэн ERP системийг нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах, үйл ажиллагааг жигдрүүлэх

## **2.2. Мэдээллийн технологи, хэргийн хөдөлгөөний удирдлагыг хэрэгжүүлэх**

2.2.2. Шүүхийн дотоод сүлжээний зохион байгуулалтыг сайжруулах

2.2.3. Шүүх, шүүхийн захиргааны үйл ажиллагаанд мэдээллийн технологийн инновац нэвтрүүлэх

2.2.4. Хэргийн хөдөлгөөний удирдлагын e-case системийн хүсэлтийн тоо, хэрэглэгчийн алдааг багасгах

2.2.5. Хэргийн хөдөлгөөний удирдлагын чиглэлээр дотоод хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх

2.2.6. Мэдээллийн технологи, хэргийн хөдөлгөөний удирдлагын чиглэлээр дотоод сургалтыг зохион байгуулах

2.2.7. Шүүхийн шийдвэрийг цахим хуудаст холбогдох журмын дагуу байршуулж буй байдалд хяналт тавих

## **2.3. Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх**

2.3.1 Шүүхийн иргэдийн төлөөлөгчийг сонгож, шүүх хуралдаанд оролцуулах үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийх, хяналт-шинжилгээний үр дүнг үндэслэн зохих арга хэмжээг авч хэрэгжүүлэх

2.3.2. Архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийх, үр дүнг үндэслэн зохих арга хэмжээг авч хэрэгжүүлэх

2.3.3. Эрүүгийн болон зөрчлийн хэрэгт хураагдсан хөрөнгө, орлого, эд мөрийн баримтыг хүлээж авах, шийдвэрлэхтэй холбоотой үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийх, үр дүнг үндэслэн зохих арга хэмжээг авч хэрэгжүүлэх

2.3.4. Шүүхийн хүний нөөцийн программ дахь шүүгч, ажилтны мэдээлэл, хэвийн ажиллагаанд хагас жил тутамд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, үр дүнг үндэслэн зохих арга хэмжээг авч хэрэгжүүлэх

2.3.5. Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх үйл ажиллагаанд хяналт шинжилгээ хийх, үр дүнг үндэслэн зохих арга хэмжээг авч хэрэгжүүлэх

## **2.4. Шүүхийн тусгай архивын чиглэлээр**

2.4.1 Нийт шүүхийн архивын хэрэг баримтад нэгдсэн тооллого хийх

## **ГУРАВ. ШҮҮХИЙГ ХҮНИЙ НӨӨЦӨӨР ХАНГАХ**

3.1. Шүүхийн ерөнхий зөвлөлийн болон төрийн албаны хүний нөөцийн программын бүртгэл хөтлөлтийг тухай бүр бүрэн хийж, шүүхийн Тамгын газрын ажилтны хүний нөөцийн шилжилт хөдөлгөөнийг бүртгэх, хүний нөөцийн мэдээллийн санг баяжуулах, тайланг заасан хугацаанд ирүүлэх

3.2. Хүний эрх, жендерийн эрх тэгш байдлыг хангах талаар төлөвлөгөөний биелэлтийг хангаж ажиллах

3.3. Монгол Улсын шүүхийн тухай хууль болон Төрийн албаны хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж, сул орон тоог нөхөх ажлыг зохион байгуулах

3.4. Шүүхийн захиргааны ажилтны сургалтын төлөвлөгөөг холбогдох бодлогын баримт бичиг, онол, практикт тулгуурлан боловсруулж, хэрэгжүүлэх

3.5. Шүүгч, шүүхийн захиргааны ажилтанд зэрэг дэв олгох, түүнийг төрийн шагнал, хүндэт цолд тодорхойлох асуудлыг хууль тогтоомжийн дагуу хүргүүлэх, уламжлах, шийдвэрлүүлэх

3.6. Шүүхийн Тамгын газрын дэргэдэх Ёс зүйн зөвлөлийн журамд шүүхийн захиргааны ажилтны ёс зүйн хэм хэмжээ зөрчигдөхөөс сэргийлэх, соён гэгээрүүлэх ёс зүйн сургалт зохион байгуулах

## **ДӨРӨВ. ШҮҮГЧИЙН ХАРААТ БУС БАЙДЛЫГ ХАНГАХ, ХУУЛЬ ЁСНЫ АШИГ СОНИРХЛЫГ ХАМГААЛАХ**

- 4.1. Шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдалд халдсан, алдагдуулсан шинжтэй шийдвэр гаргасан, эсхүл үйл ажиллагаа явуулсан, шүүгчийн эрх ашгийг зөрчсөн тохиолдолд шуурхай арга хэмжээ авах
- 4.2. Шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг Цагдаагийн байгууллагатай хамтран тухай бүр зохион байгуулах
- 4.3. Шүүхийн тамгын газар, Цагдаагийн байгууллагатай хамтран ажиллах төлөвлөгөө батлах, хэрэгжилтийг хангаж ажиллах
- 4.4. Шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах талаар Цагдаагийн байгууллагатай хамтарсан уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулж хэвших
- 4.5. Шүүгч, түүний гэр бүлийн гишүүний аюулгүй байдлыг хангах чиглэлээр цагдаагийн байгууллагатай хамтарсан сургалт зохион байгуулах.
- 4.6. Нөлөөллийн мэдүүлэг, тэмдэглэл болон шүүгчээс Ерөнхий зөвлөлд хандан гарсан хүсэлтийг дагуу ирүүлж шийдвэрлүүлэх талаар холбогдох арга хэмжээ авч ажиллах.
- 4.7. 2022 оны ХАСХОМ мэдүүлэх ажлыг харьяа шүүхийн хэмжээнд шуурхай зохион байгуулах, холбогдох тайлан, мэдээг хуулийн хугацаанд ирүүлэх
- 4.8. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг хуульд заасны дагуу зохион байгуулах

## **ТАВ. ШҮҮХИЙН САНХҮҮ ЭДИЙН ЗАСГИЙН БАТАЛГААГ ХАНГАХ ЧИГЛЭЛЭЭР**

- 5.1. Төсвийн ерөнхийлөн захирагчид 2022 оны аудитлагдсан санхүүгийн тайланг И-тайлан болон цаасан тайлангаар хуульд заасан хугацаанд хүргүүлэх
- 5.2. Төсвийн ерөнхийлөн захирагчид 2023 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланг И-тайлан болон цаасан тайлангаар хүргүүлэх
- 5.3. Төрийн хэмнэлтийн хуулийг мөрдөж, төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулж, төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүр хуульд заасан хугацаанд Төсвийн ерөнхийлөн захирагчид ирүүлэх

5.4. Анхан болон давж заалдах шатны шүүхийн 2024 оны төсвийн төслийг боловсруулах

5.5. Төсвийн ерөнхийлөн захирагчид шилжүүлэх, актлах үндсэн хөрөнгийн саналаа тайлант оны 4 ба 10 дугаар сард ирүүлэх, эд хөрөнгийн тооллогыг хуульд заасан хугацаанд зохион байгуулах

5.6. Худалдан авах ажиллагааны 2023 оны төлөвлөгөөнд тусгагдсан худалдан авалтыг цахим системээр зарлах, худалдан авах ажиллагааг зохион байгуулах

5.7. Шилэн дансны хуулийг хэрэгжүүлж ажиллах

### **ЗУРГАА. МЭДЭЭЛЛЭЭР ХАНГАХ ЧИГЛЭЛЭЭР**

6.1. Шүүхэд итгэх иргэдийн итгэлийн түвшнийг тодорхойлох судалгаа хийх

6.2. “Шүүхийн шийдвэрийг олон нийтэд мэдээлэх” журмын 3.1.1.2-т заасан нөхцөл байдал үүссэнтэй холбогдуулан тоймыг бэлтгүүлэх

6.3. Шүүхийн цахим хуудаст байршуулсан шүүхийн шийдвэрийн тойм, шүүхийн процессын тоймыг олон нийтэд түгээх

6.4. Шүүхийн шийдвэрийн болон процессын тоймын статистик мэдээллийг Хэвлэл мэдээллийн хэлтэст ирүүлэх

6.5. “Шүүхийн үйл ажиллагааг сурталчлах өдөрлөг”-ийг шүүх тус бүр төлөвлөгөө гаргаж, жилд 2-оос доошгүй удаа зохион байгуулах

6.6. Шүүхийн статистик, тайлан, мэдээлэл лавлагаа, үйлчилгээг хэрэг, маргааны тоо, төрлөөр хэрэглэгчид ойлгомжтой товч байдлаар бэлтгэх, хүргэх ажиллагааг үр өгөөжтэй хэрэгжүүлэх

## ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ШҮҮХИЙН ТАМГЫН ГАЗРЫН 2023 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2023.12.04

Сайншанд сум.

### НЭГ. УДИРТГАЛ

Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Шүүхийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Захиргааны ерөнхий хууль, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, эдгээртэй нийцүүлэн гаргасан бусад хууль тогтоомж болон Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2022 оны 28 дугаар тогтоолоор батлагдсан “Анхан болон давж заалдах шатны шүүхийн тамгын газрын үйл ажиллагааны нийтлэг журам”-д тус тус заасны дагуу байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг төлөвлөсөн хугацаанд нь хийж гүйцэтгэн, хууль тогтоомжид заасан чиг үүргээ хэрэгжүүлж ажиллалаа.

Дорноговь аймаг дахь Шүүхийн Тамгын газар нь 2023 онд Эрүү, Иргэн, Захиргааны хэргийн анхан шатны 3 шүүх, Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхэд, нийт 11 шүүгч, Төрийн захиргааны 13, Төрийн үйлчилгээний 9, нийт 39 орон тоотой, 1,450,025,100.00 төгрөгийн төсөвтэйгөөр шүүн таслах ажиллагааг хэвийн тасралтгүй явуулах, шүүхийн бие даасан хараат бус байдлыг хангах үйл ажиллагаагаа хэрэгжүүлэн ажиллаж байна.

1. “Шүүхийн бие даасан байдлыг хангах” чиглэлээр :
  - 1.1. Шүүхийн захиргаа, удирдлага -11
  - 1.2. Мэдээллийн технологи, хэргийн хөдөлгөөний удирдлага-7;
  - 1.3. Хяналт-шинжилгээ үнэлгээ хийх-5
  - 1.4. Шүүхийн тусгай архив-1
2. “Шүүхийн хүний нөөцийг удирдах” чиглэлээр -6
3. “Шүүгчийн хараат бус байдлыг хангах, хууль ёсны ашиг сонирхлыг
4. хамгаалах” чиглэлээр-8
5. “Шүүхийн санхүү, эдийн засгийн баталгааг хангах” чиглэлээр -7
6. “Мэдээллээр хангах” чиглэлээр -6 ажил тус тус төлөвлөж,
7. төлөвлөгөөний дагуу ажлыг дараах байдлаар хийж гүйцэтгэлээ.

## ХОЁР. ШҮҮХИЙН БИЕ ДААСАН БАЙДЛЫГ ХАНГАХ ЧИГЛЭЛЭЭР ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ

### 2.1. Захиргааны удирдлагыг хэрэгжүүлэх, эрх зүйн орчныг боловсронгуй болгох үйл ажиллагаа

2.1.1. Нийт ажилтнуудыг хамруулан нийгэмд тустай, сайн үйлсийн арга хэмжээ зохион байгуулах, энэ талаар шүүхийн цахим сайт, мэдээллийн самбарт болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах арга хэмжээний хүрээнд дараах ажлыг хийж гүйцэтгэлээ.

Олон Улсын Хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг угтаж 2023 оны 05 дугаар сарын 23-ны өдөр Дорноговь аймаг дахь шүүхийн тамгын газар албан хаагчдын хүүхдүүдийн хийсэн уран бүтээлээр үзэсгэлэн гаргаж, шүүхтэй танилцууллаа.



*Зураг. Хүүхдүүдийн бүлээр үзэсгэлэн гаргасан байдал*







Олон Улсын Хүүхдийн эрхийг хамгаалах 2023 оны 06 дугаар сарын 01-ний өдөр тус Шүүхийн тамгын газраас бага насны хүүхдүүдийн дунд машины уралдаан, дунд насны хүүхдүүдийн дунд шоо эвлүүлэх зэрэг тэмцээн уралдаан зохион байгууллаа.



Зураг. 2023.06.01

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2020 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн "Мод тарих үндэсний өдөр зарлах тухай" 63 дугаар зарлиг, "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд намрын бүх нийтээр мод тарих Үндэсний өдрийн нээлтийн үйл ажиллагааг Сайншанд хотод 2023 оны 10 дугаар сарын 16-ны өдөр аймгийн Төв талбайн цэцэрлэгт хүрээлэнд зохион байгуулагдсан үйл ажиллагаанд Дорноговь аймаг дахь шүүхийн тамгын газрын хамт олон оролцож 300 ширхэг хайлаас, 300 ширхэг улиас модны суулгац тарилаа.



Төв цэцэрлэгт хүрээлэн

Дорноговь аймаг дахь шүүхийн тамгын газраас 2023 оны 10 дугаар сарын 22-ны өдөр цаг агаарын хүндрэлтэй нөхцөлд ажилласан Сайншанд хотын захирагчийн ажлын албаны ажилчдад халуун аарцаар дайлж сайн үйлсийн аянд нэгдэж оролцлоо.



2023.10.22

Дорноговь аймаг дахь шүүхийн тамгын газраас Сайншанд сумын 6 дугаар багт оршин суух амьжиргааны түвшин доогуур айл өрхөд хүнсний бүтээгдэхүүн өгч Үндэсний өгөх өдөрт нэгдлээ.




2023.10.10

"НАМАЙГ ХАМГААЛ" аяны хүрээнд "Хүүхдийн хүмүүжил, төлөвшил, хөгжил, эцэг эхийн үүрэг, оролцоо, хариуцлага" сэдэвт сургалтад хамрагдаж, Дорноговь аймаг дахь шүүхийн тамгын газрын "Эцэг эхийн зөвлөл"-ийг шинэчлэн байгуулав.



Намайг хамгаал аян



2.1.2. Шүүхийн ерөнхий зөвлөлөөс ирүүлсэн хууль тогтоомж, дүрэм журам, аргачлал, стандартын "Нэгдсэн сан" бүрдүүлэх, тухай бүр шүүгч, ажилтнуудад танилцуулах, судалгаа хийх, үр нөлөөтэй санал өгөх, хагас бүтэн жилээр тайлагнах ажлын хүрээнд:


Шүүхийн ерөнхий зөвлөл, Улсын дээд шүүх болон бусад байгууллагаас ирүүлсэн 76 судалгааг чанартай, шуурхай гаргаж холбогдох байгууллагуудад тухай бүр хүргүүлж ажиллалаа.

Мөн Монгол Улсын дээд шүүх болон Шүүхийн Ерөнхий зөвлөлөөс ирүүлсэн хууль тогтоомж болон дүрэм, журмын шинэчлэлт, нэмэлт, өөрчлөлттэй холбогдуулан ирүүлсэн 22 албан бичиг, төслийг нийт шүүгч, ажилтнуудад танилцуулж, саналыг нэгтгэн холбогдох байгууллагуудад уламжилсан. Дараах 10 хууль, журам, аргачлалын төсөлд санал хүргүүлсэн байна.

| №   | Ирсэн бичгийн огноо, дугаар          | Ирүүлсэн байгууллага          | Товч утга  | Явуулсан бичиг  |
|-----|--------------------------------------|-------------------------------|--|---|
| 1.  | 2023.01.27<br>03                     | Эвлэрүүлэн зуучлагчдын зөвлөл | “Эвлэрүүлэн зуучлах ажиллагааны журам”-д нэмэлт өөрчлөлт оруулах тухай         | Эрүү, иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2023.02.17-ны өдрийн 87 дугаартай албан бичгээр хариу хүргүүлэв. |
| 2.  | 2023.05.02<br>01/816                 | Шүүхийн Ерөнхий зөвлөл        | “Шүүх байгуулах тухай” хуулийн төсөл   | Эрүү, иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2023.05.04-ний өдрийн 110 дугаартай албан бичгээр хүргүүлэв.     |
| 3.  | 2023.05.02<br>01/816                 | Шүүхийн Ерөнхий зөвлөл        | “Шүүх байгуулах тухай” хуулийн төсөл   | Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2023.05.04-ний өдрийн 41 дугаартай албан бичгээр хүргүүлэв.                |
| 4.  | 2023.03.03                           | Шүүхийн Ерөнхий зөвлөл        | “Албаны орон сууц эзэмшүүлэх журам”-ийн төсөл                                  | Анхан болон Давж заадлах шатны шүүхээс 2023.03.03-ны өдөр цахимаар хүргүүлэв.                                     |
| 5.  | 2023.05.15                           | Шүүхийн Ерөнхий зөвлөл        | Орон сууцны дэмжлэг үзүүлэх журам  | Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхээс 2023.05.18-ны өдөр цахимаар хүргүүлэв.                           |
| 6.  | 2023.05.15                           | Шүүхийн Ерөнхий зөвлөл        | Шүүгч, шүүхийн ажилтанд буцалтгүй тусламж олгох журам                          | Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхээс 2023.05.18-ны өдөр цахимаар хүргүүлэв.                           |
| 7.  | 2023.05.15                           | Шүүхийн Ерөнхий зөвлөл        | Шүүгч, шүүхийн захиргааны ажилтныг гадаад улсын сургалтад хамруулах журам      | Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхээс 2023.05.18-ны өдөр цахимаар хүргүүлэв.                           |
| 8.  | 2023.06.14-<br>ний өдрийн<br>01/1124 | Шүүхийн Ерөнхий зөвлөл        | “Монгол Улсын шүүх эрх мэдлийн хөгжлийн бодлого”-ын төсөл                      | Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2023.06.20-ны өдрийн 130 дугаартай албан бичгээр хүргүүлэв.      |
| 9.  | 2023.06.30                           | Шүүхийн Ерөнхий зөвлөл        | “Шүүхийн захиргааны ажилтны нийгмийн хамгааллын хөтөлбөр”-ийн төсөл            | Дорноговь аймаг дахь шүүхийн Тамгын газраас 2023.07.07-ны өдөр цахимаар хүргүүлэв.                                |
| 10. | 2023.08.14-<br>ний өдрийн<br>01/1435 | Шүүхийн Ерөнхий зөвлөл        | “Анхан болон давж заалдах шатны шүүхийн шүүгчид нэмэлт урамшуулал олгох тухай” | Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2023.08.25-ны өдрийн 72 дугаартай албан бичгээр хүргүүлэв.                 |

*Хууль, журмын төсөлд тусгуулахаар хүргүүлсэн саналын жагсаалт*

Шүүхийн ерөнхий зөвлөл болон холбогдох бусад байгууллагаас ирүүлсэн 25 хууль, журмыг нэгтгэн ERP системд бүртгэж мэдээллийн сан үүсгэж шүүгч, ажилтнуудыг мэдээллээр хангаж ажиллаж байна.



Зураг. Санал авахаар ирүүлсэн албан бичгийн жагсаалт

### 2.1.3.Тухайн шүүх, шүүгчдэд мэдээлэл танилцуулж хэвших

Анхан болон давж заалдах шатны шүүхийн шүүгч нарт хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас бусад 502 ирсэн албан бичиг, 130 өргөдөл гомдол ирснийг цаг тухайд нь архив бичиг хэргийн эрхлэгч 7 хоног бүрээр танилцуулан ажиллаж байна.

ТУС ШҮҮХЭД ИРСЭН АЛБАН БИЧИГ, ӨРГӨДӨЛ ГОМДЛЫН ТАЛААРХ ТАНИЛЦУУЛГА

2023.05.01-05.05

| Д/д  | Сар өдөр   | Хаанаас, хэнээс                                     | Товч утга  | Хэнд шилжүүлсэн  | Шийдвэрлэсэн байдал                                 | Тайлбар    |
|------|------------|---|--|--|---|------------|
| 168. | 2023.05.01 | Шүүхийн ерөнхий зөвлөл                              | Шүүгчид чөлөө олгосон судалгаа ирүүлэх тухай           | АБХЭ<br>Н.Норжинлхамд                                    | Цахим хаягаар судалгааны хариу хүргүүлсэн.          | 2023.05.02 |
| 92.  | 2023.05.01 | Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүх     | М.Оюу-Эрдэнийг шилжүүлэн ажиллуулах тухай              | -  | Тамгын газрын даргад танилцуулсан.                  | 2023.05.01 |
| 93.  | 2023.05.02 | Шүүхийн ерөнхий зөвлөл                              | Шүүх байгуулах тухай хуулийн төсөлд санал авах тухай   | Ерөнхий шүүгчийн туслалуудад Шүүхийн захиргааны ажилчдад | Шүүхүүдийн саналыг нэгтгэж цахим хаягаар хүргүүлсэн | 2023.05.05 |
| 94.  | 2023.05.02 | Шүүхийн ерөнхий зөвлөл                              | Эрдэм шинжилгээний өгүүлийн удирдамж хүргүүлэх тухай   | Эвлэрүүлэн зуучлагч О.Батбямбад                          | Шүүхийн захиргааны албан хаагчдад танилцуулсан      | 2023.05.02 |
| 95.  | 2023.05.02 | Нийт шүүгчдийн чуулган зохион байгуулах ажлын хэсэг | Мэдээлэл хүргүүлэх тухай                               |  | Шүүгч нарт танилцуулсан.                            | 2023.05.02 |
| 96.  | 2023.05.03 | Шүүхийн ерөнхий зөвлөл                              | Чиглэл хүргүүлэх тухай                                 | АБХЭ<br>Н.Норжинлхамд                                    | Тамгын газрын даргад танилцуулсан.                  | 2023.05.03 |
| 97.  | 2023.05.03 | Шүүхийн ерөнхий зөвлөл                              | 2024 оны төсвийн хязгаарын санал авах тухай            | Нягтлан Д.Даваажууд                                      | 2024 оны төсвийн төсөл хүргүүлсэн.                  | 2023.05.10 |
| 98.  | 2023.05.03 | Аймгийн цагдаагийн газар                            | Шийтгэх тогтоолын хуулбар авах тухай                   | АБХЭ<br>Н.Норжинлхамд                                    | Хэргээс хуулбарлаж өгөв.                            | 2023.05.03 |
| 99.  | 2023.05.03 | Аймгийн цагдаагийн газар                            | Шийтгэх тогтоолын хуулбар авах тухай                   | АБХЭ<br>Н.Норжинлхамд                                    | Хэргээс хуулбарлаж өгөв.                            | 2023.05.03 |
| 100. | 2023.05.03 | Б.Баярцэцэг   | Өргөдөл, Хэргээс шүүхийн шийдвэрийн хуулбар авах тухай | АБХЭ<br>Н.Норжинлхамд                                    | Хэргээс хуулбарлаж өгөв.                            | 2023.05.03 |
| 101. | 2023.05.05 | Г.Алтанцэцэг  | Ажилд өвсөн тушаалын хуулбар авах тухай                | АБХА<br>Н.Норжинлхамд                                    | Хуулбарлаж өгөв.                                    | 2023.05.09 |
| 102. | 2023.05.05 | Хан Бан Буурал чандмань ХХК                         | Тодорхойлолт гаргуулах тухай                           | АБХА<br>Н.Норжинлхамд                                    | 68 дугаартай албан бичгээр хариу хүргүүлэв.         | 2023.05.09 |

Мэдээ гаргасан: Архив, бичиг хэргийн эрхлэгч  Н.Норжинлхам

Зураг. Ирсэн албан бичиг, өргөдөл гомдол танилцуулсан байдал

2.1.4 Шүүхийн ерөнхий зөвлөлөөс хүргүүлсэн цахим талбарт шүүхийн Тамгын газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг тухай бүр оруулах, явцыг эрх бүхий байгууллагаас баталсан байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний тайлан гаргах журмын дагуу улирал бүр цахим талбарт тайлагнах

Шүүхийн ерөнхий зөвлөлөөс хүргүүлсэн цахим талбарт шүүхийн Тамгын газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг хагас жилийн байдлаар 2023 оны 08 дугаар сарын 11-ний өдөр, жилийн эцсийн байдлаар 2023 оны 11 дүгээр сарын 11.24-ний өдөр тус тус байршуулсан байна.


| №                             | Үйл ажиллагаа | Шалгуур үзүүлэлт  | Гүйцэтгэл | Тухайн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд тулгарч буй хүндрэл, бэрхшээл, шийдвэрлэх шаардлагатай асуудал |
|-------------------------------|---------------|---|-----------|--|
| Хэргийн хөдөлгөөний удирдлага |               |   |           |  |
| 7                             |               | Хэрэг, нэхэмжлэл, хүсэлт, гомдол хуваарилахтай холбоотой ШЗТ-ын эх хувь, он цагийн дарааллаар |           |  |

Зураг. Цахим талбарт тайлан оруулсан байдал

2.1.5. Шүүхийн үйл ажиллагааны ил тод байдал, шүүхийн үйлчилгээний талаар олон нийтэд мэдээлэх иргэдэд зориулсан мэдээллийн самбарыг шүүхийн байрны гадна талд ил тод байршуулах, мэдээллийг тогтмол шинэчилж хэвших

Шүүхийн нээлттэй танхимд Тамгын газрын мэдээллийн самбарыг байршуулан ажилладаг ба мэдээллийг тогтмол шинэчилж байна.

Мөн шүүхийн байрны гадна талд Тамгын газрын вэб сайт, фэйсбүүк хуудас, холбоо барих утасны дугаар, холбогдох байгууллагуудын цахим хаяг зэрэг мэдээллийг байршуулсан гэрэлт самбарыг байршуулан ажиллаж байна. Самбарын эхэнд байрлах QR кодыг гар утасны камераар уншуулан Тамгын газрын вэб хуудсанд 24 цагийн турш зочилж, тэндээс өөрт хэрэгцээтэй мэдээллээ авах бүрэн боломжийг нээж өгсөн байна.



*Мэдээллийн гэрэлт самбар*

2.1.6. Иргэдэд шүүхийн байгууллага, шүүхийн байрыг заасан таних тэмдэг, тэмдэглэгээ, самбарыг шүүхийн байрны ойролцоо нийтийн эзэмшлийн зам, талбай бүхий зохих газарт ил тод байршуулах

Шүүхийн байрыг заасан гэрэлт таних тэмдгийг Сайншанд хотын Гэр бүлийн талбайн дэргэд төв замын хажууд байршууллаа.



*Сайншанд сумын “Гэр бүл”-ийн талбайн баруун талд байршил заасан самбар байршуулсан байдал*

### 2.1.7. “Шүүхийн Тамгын газрын мэдээллийн нэгдсэн сан”-ийн хөтлөлтийг сайжруулах

Шүүхийн Тамгын газрын мэдээллийн нэгдсэн сангийн мэдээллийн баяжилтыг сар бүр хийж байна.

### 2.1.8. Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн ач холбогдлын талаар иргэдэд ухуулан таниулах ажлыг хэрэгжүүлэх, олон нийтэд сурталчлах

Эвлэрүүлэн зуучлалын тухай хууль, Шүүхийн Ерөнхий зөвлөлийн тогтоол, Эвлэрүүлэн зуучлалын зөвлөлийн тогтоол, холбогдох дүрэм, журмыг өдөр бүр мөрдлөг болгон хэрэгжүүлэн ажиллаж байна.


Эрх зүйн маргааныг шүүхийг бус аргаар, Иргэний хууль, Гэр бүлийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хуульд нийцүүлэн, бусдын эрх, ашиг сонирхлыг хөндөөгүй, талуудын тохиролцоонд үндэслэж шийдвэрлэх нөхцөлийг хангаж ажиллалаа.

Тайлант хугацаанд маргааны талуудаас ба бусад этгээдээс гаргасан ямар нэгэн гомдолгүйгээр, хэвийн тасралтгүй үйл ажиллагааг хангаж эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явагдсан.

Эвлэрүүлэн зуучлагчийн өрөөнд 70522055 дугаартай телефоны аппарат суурилуулсан өгч, маргааны талуудыг дуудан ирүүлэн, уулзалт зохион байгуулахад дэмжлэг үзүүлэн ажиллаж байна.



Эвлэрүүлэн зуучлагч нь албан өрөөнөөс гадна тусгайлан тохижуулсан Эвлэрүүлэн зуучлал явуулах уулзалтын тусдаа өрөөтэй ба энэ нь уулзалтыг тухтай, цаг хугацаанд баригдалгүй явуулах нөхцөл боломжоор хангасан байна.








*Эвлэрүүлэн зуучлагчийн уулзалтын өрөө*



Шүүх дэх эвлэрүүлэн зуучлах ажиллагааны тайлан мэдээг улирал, хагас жил, бүтэн жилээр гаргаж, тухай бүр Тамгын газар, шүүхүүд, Шүүхийн ерөнхий зөвлөлд хүргүүлсэн ба байгууллагын албан ёсны мэдээллийн сайт, олон нийтийн сүлжээнд байршуулан ажиллаж байна.

Эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд дахь маргааны тоо, чанарыг сайжруулж, иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүн таслах ажиллагааны ачааллыг 35,2 хувиар бууруулсан байна. 2023 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн байдлаар иргэний хэргийн анхан шатны шүүхээс хэргээр ирүүлсэн болон ажиллагаанд өргөдлөөр хүлээн авсан 353 маргаанд талуудын сайн дурын тохиролцооны үндсэн дээр 199 эвлэрлийн гэрээ байгуулсан байна.

Эвлэрүүлэн зуучлалын зөвлөлийн тогтоолоор батлагдсан өргөдөл гаргах загварыг иргэн, гэр бүл, хөдөлмөрийн маргааны төрлөөр бэлтгэн хэвлэж, иргэд, байгууллагуудад гарын авлага болгон тараасан.



**Өргөдлийн загвар**

Мөн эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд гаргах өргөдлийн загварыг цаасан суурьтай бус дэвшилт технологи ашиглаж QR-г гар утасны камераар уншуулан авах боломжтой болгож, мөн цаасаар хэвлүүлж шүүхээр үйлчлүүлэгч нарт хүргэж байна.

**МОНГОЛ УЛС**

Дорноговь аймаг дахь анхан болон давж заалдах шатны шүүх, шүүхийн тамгын газар

Дорноговь аймаг дахь шүүхийн тамгын газрын цахим веб хуудас руу доорх QR кодыг уншуулан мэдээлэл авах боломжтой



Эвлэрүүлэн зуучлалд өргөдөл загварыг дээрх QR код уншуулан та авах боломжтой



Шүүхийн иргэдийн төлөөлөлийн талар дээрх QR кодыг уншуулан мэдээлэл авах боломжтой



Иргэний хэргийн анхан шатны гаргах шүүхэд нэхэмжлэл гаргах загварыг дээрх QR уншуулан авах болох боломжтой

Мөн эвлэрүүлэн зуучлах



**Урилга**  
 “МОНГОЛ УЛСАД АРИЛЖААНЫ  
 ЭВЛЭРҮҮЛЭН ЗУУЧЛАЛЫГ БЭХЖҮҮЛЭХ НЬ”  
 ТӨСӨЛ (2023-2025)

**ТӨСЛИЙН НЭЭЛТИЙН АЖИЛЛАГАА**

- 2023 оны 10-р сарын 10-ны өдөр, 14:00-17:00 цагт
- Хууль зүй, дотоод хэргийн яам, 2 давхарт 201А танхим

**ХӨТӨЛБӨР**

- 13:30-14:00 Бүртгэл, нетворкинг
- 14:00-14:30 Нээлтийн үг
  - Европын Сэргэн Босголт Хөгжлийн Банк
  - Европын Холбооноос Монгол Улсад суугаа Төлөөлөгчийн газар
  - Стивен Кент, ОУЭЗХБ-ын Суурин төлөөлөгч
  - Хууль зүй, дотоод хэргийн яам
  - Шүүхийн ерөнхий зөвлөл
- 14:30-15:30 Илтгэл, презентаци
  - Надяа Александер, Сингапурын менежментийн их сургуулийн эрх зүйн профессор (практик), Сингапурын олон улсын маргаан шийдвэрлэх академийн захирал
  - Эвлэрүүлэн Зуучлагчдын Зөвлөл
  - Монголын Хуульчдын Холбооны дэргэдэх Эвлэрүүлэн зуучлалыг дэмжих асуудал эрхэлсэн хороо
  - Монголын Үндэсний Худалдаа, Аж Үйлдвэрийн Танхимын дэргэдэх Бизнесийн маргааныг эвлэрүүлэн зуучлах төв
- 15:30-15:45 Төслийн хүлээгдэж буй үр дүн С. Агьзул, ОУЭЗХБ-ын Төслийн зохицуулагч
- 15:45-16:00 Санамж бичигт гарын үсэг зурах ёслол ХЭДХЯ-тай зурах санамж бичиг (дэд сайд Б.Солонгоо) ШЕЗ-тэй зурах санамж бичиг (дарга Р.Онончимэг) МХХ-той зурах санамж бичиг (ерөнхийлөгч П.Одгэрэл) МУХАҮТ-тай зурах санамж бичиг (ерөнхийлөгч Д.Энхтүвшин)
- 16:00-16:30 Хаалтын үг
  - Вероника Брадаутану, ЕСБХБ-ны Хууль зүйн газрын Хууль зүйн шилжилтийн багийн Ерөнхий зөвлөх
  - Стивен Кент, ОУЭЗХБ-ын Суурин төлөөлөгч
- 16:30-17:00 Цайны завсарлага, нетворкинг

### Цахим сургалтын урилга

2023 оны 10 дугаар сарын 10-ны өдөр “Арилжааны эвлэрүүлэн зуучлалыг бэхжүүлэх нь” төслийн сургалтад цахимаар;

2023 оны 11 дүгээр сарын 01-ний өдөр Эвлэрүүлэн зуучлалын тухай хууль хэрэгжсэний 10 жилийн ойн ”Эвлэрүүлэн зуучлалын үр нөлөө ба цаашид анхаарах асуудал” сэдэвт арга хэмжээ, уулзалтад цахимаар тус тус оролцсон байна.

Эрхэм хүндэт таныг  
 Эвлэрүүлэн зуучлалын тухай хууль хэрэгжсэний  
 10 жилийн ойд зориулсан

ЭВЛЭРҮҮЛЭН ЗУУЧЛАЛЫН ҮР НӨЛӨӨ БА ЦААШИД АНХААРАХ  
 АСУУДАЛ СЭДЭВТ ХЭЛЭЛЦҮҮЛЭГТ УРЬЖ БАЙНА

Хаана: Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн хурлын танхим

Хэзээ: 2023.11.01 09:00 цагт

2023 оны 11 дүгээр сарын 04-ний өдөр Сайншанд хотноо “Хүүхэд гэр бүлийн хүчирхийлэл, гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд төрийн албан хаагчдын үүрэг оролцоо, хариуцлага” сэдэвт чадавхжуулах сургалтад хамт олноороо оролцлоо.



Зураг. 2023.11.04

Төлөвлөгөөт ажлын дагуу шүүхэд харьяалагдах Дорноговь аймгийн Айраг, Алтанширээ, Даланжаргалан, Дэлгэрэх, Мандах, Иххэт, Сайхандулаан, Сайншанд, Хатанбулаг, Хөвсгөл зэрэг 10 сумын иргэдэд 2023 оны 11 дүгээр сарын 6-13-ны өдрүүдэд шүүхийн Тамгын газраас шүүхийн шүүн таслах ажиллагаа, Шүүхийн иргэдийн төлөөлөгч, Эвлэрүүлэн зуучлах ажиллагааны талаарх сургалтыг зохион

Дорноговь аймаг дахь шүүхийн Тамгын газар байгуулж, мэдээлэл, гарын авлагаар ханган ажиллалаа. Сайншанд суманд зохион байгуулагдсан нээлттэй хаалганы өдөрлөгт тогтмол оролцож байна.



*2023.11.07 Сайхандулаан сумын иргэд*



*2023.11.09 Хатанбулаг сумын иргэд*



Төлөвлөгөөт ажлын дагуу шүүхэд харьяалагдах Дорноговь аймгийн Сайншанд сумын Зүүнбаян багийн иргэдэд 2023 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр Шүүх дэх иргэдийн төлөөлөгч, Эвлэрүүлэн зуучлах ажиллагааны талаарх сургалтыг зохион байгуулж, мэдээлэл, гарын авлагаар ханган ажиллалаа.



2023.11.20 Сайншанд сумын Зүүнбаян багийн  
иргэд

Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн сэтгэл зүйч Б.Нямаа 2023 оны 11 дүгээр сарын 23-24-ний өдрүүдэд албан томилолтоор ирж, эвлэрүүлэн зуучлах ажиллагааны гэр бүлийн 6 маргааны уулзалтад оролцуулсан нь маргааныг шийдвэрлэхэд эерэг сайнаар нөлөөлсөн. Мөн шүүхийн нийт шүүгч, ажилтанд “Ажлын байран дахь сэтгэл зүй” сэдвээр сургалт зохион байгуулж, ажлын ачааллаас үүдэлтэй бухимдал стрессийг хэрхэн багасгах, арилгах аргаас суралцан, дасгал ажиллаж, харилцан яриа өрнүүллээ.



2023.11.23




2023.11.24

2023 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн байдлаар Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2 дахь хэсэгт зааснаар 199 маргаанд эвлэрлийн гэрээ байгуулсан ба шүүгчийн захирамжаар 190 эвлэрлийн гэрээг баталгаажуулсан байна. 9 эвлэрлийн гэрээг шүүгчийн захирамжаар баталгаажуулахаар хүргүүлээд байна.

2.1.9. Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн нэрсийн нэгдсэн жагсаалт бүрдүүлэх ажлыг зохион байгуулах

Шүүхийн Ерөнхий зөвлөлийн 2023 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн 239 дүгээр тогтоолоор баталсан “Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн жишиг тоо”-г баримтлан Улсын бүртгэлийн ерөнхий газраас 709 иргэний нэрсийг санамсаргүй аргаар сонгож ирүүлсний дагуу тус шүүхийн харьяаллын нутаг дэвсгэрийн төрийн захиргааны байгууллага болон Цагдаагийн Ерөнхий газрын Мэдээлэл дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албатай хамтран Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 59 дүгээр зүйлд заасан шаардлагыг хангасан эсэхийг нягтлан шалгаж, Тамгын газрын даргын 2023 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн А/41 дугаар тушаалаар 472 иргэнийг Шүүхийн иргэдийн төлөөлөгчдийн нэрсийн жагсаалтаар баталгаажуулсан байна.





### *Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн нэрсийн жагсаалт баталсан тушаал*

Анхан болон давж заалдах шатны шүүхийн Тамгын газрын үйл ажиллагааны нийтлэг журмын 4.2.1-т заасан шүүхийн иргэдийн төлөөлөгчийг шалгаруулах, сонгохтой холбоотой журмыг хэрэгжүүлэх, шүүх хуралдаанд оролцох бүрэн эрхийг хангах үйл ажиллагааны хүрээнд:

Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1. дэх хэсэгт Энэ хуулийн 62.2-т заасан иргэдийн төлөөлөгчийн нэрсийн жагсаалтаас иргэдийн төлөөлөгчийг шалгаруулах ажлыг тухайн шүүхийн Тамгын газар зохион байгуулна гэж заасны дагуу шүүх хуралдааны тов гармагц 10 хүний нэрсийн дэд жагсаалтыг цахимаар эрэмбэлэн тохиолдлын журмаар сонгож, Тамгын газрын даргын тушаалаар баталж байна.

Бүрэлдэхүүнтэй хянан шийдвэрлэгдэж буй шүүх хуралдаанд оролцохоор сонгогдож шүүхэд хүрэлцэн ирсэн иргэдийн төлөөлөгчдөд Шүүхийн тухай хууль, Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох иргэдийн төлөөлөгчийн оролцоо, иргэдийн төлөөлөгчийг сонгон шалгаруулах, тангараг өргөх, хөлс олгох талаарх мэдээлэл өгч, Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн нэгдсэн систем хөтлөн анх удаа шүүх хуралдаанд иргэдийн төлөөлөгчөөр оролцож тангараг өргөсөн 26 иргэдийн төлөөлөгчийн бүртгэлийг гарын үсэг зуруулан тангараг өргөсөн бүртгэлийн дэвтэрт бүртгэсэн байна. Дэд жагсаалтаар сонгогдсон иргэдийн төлөөлөгчдөд “Иргэдийн

төлөөлөгчийн эрх зүйн байдлын тухай” ойлголт бий болгох үүднээс гарын авлага тараан, шүүхийн байрны мэдээллийн хэсэгт байршуулж иргэдийн төлөөлөгчийн оролцоог идэвхжүүлэх хүрээнд ажиллаж байна.

2023 онд бүрэлдэхүүнтэй хянан шийдвэрлэсэн 25 шүүх хуралдааны мэдээллийг “Иргэдийн төлөөлөгчийн нэгдсэн систем”-д бүртгэж, иргэдийн төлөөлөгчийн 26 дэд жагсаалтыг баталсан. Үүнээс 25 шүүх хуралдаан шийдвэрлэгдэж, 6 шүүх хуралдаан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад зохигчид эвлэрч, хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн байна. Шүүх хуралдаан иргэдийн төлөөлөгчөөс шалтгаалан хойшилсон тохиолдол гараагүй байна.

Шүүх хуралдаанд оролцох иргэдийн төлөөлөгчөөр сонгогдсон иргэнд шүүх хуралдаан болохоос ажлын таваас доошгүй өдрийн өмнө мэдэгдэх хуудсаар болон утсаар мэдэгдэж, баримтыг хэрэгт хавсаргах бөгөөд иргэдийн төлөөлөгчөөр сонгогдсон иргэний 12 ажил олгогчид мэдэгдэх хуудас хүргүүлсэн байна.

| №  | Хэргийн дугаар | Хэргийн эзэн                 | Тайлбар             | Тайлбар         | Тайлбар                                   |
|----|----------------|------------------------------|---------------------|-----------------|---|
| 15 | 8975           | Э.Цолмонхүү                  | 2023-06-20 10:00:00 | Эрүүгийн шүүх   | Дорноговь аймаг дахь шүүхийн тамгын газар |
| 16 | 8682           | М.Шижирбилэг                 | 2023-04-27 10:30:00 | Эрүүгийн шүүх   | Дорноговь аймаг дахь шүүхийн тамгын газар |
| 17 | 8645           | Д.Дамдинпүрэв                | 2023-04-20 15:00:00 | Эрүүгийн шүүх   | Дорноговь аймаг дахь шүүхийн тамгын газар |
| 18 | 8621           | Ө.Дашням                     | 2023-04-20 13:00:00 | Эрүүгийн шүүх   | Дорноговь аймаг дахь шүүхийн тамгын газар |
| 19 | 8620           | Ж.Доржсамба                  | 2023-05-29 10:00:00 | Эрүүгийн шүүх   | Дорноговь аймаг дахь шүүхийн тамгын газар |
| 20 | 8387           | Ж.Гантулга                   | 2023-03-14 11:00:00 | Иргэний шүүх    | Дорноговь аймаг дахь шүүхийн тамгын газар |
| 21 | 8386           | Ж.Гантулга                   | 2023-03-14 09:00:00 | Иргэний шүүх    | Дорноговь аймаг дахь шүүхийн тамгын газар |
| 22 | 8305           | Н.Бүрэнбаяр                  | 2023-03-30 10:00:00 | Эрүүгийн шүүх   | Дорноговь аймаг дахь шүүхийн тамгын газар |
| 23 | 8304           | Э.Сандаг                     | 2023-02-28 10:00:00 | Эрүүгийн шүүх   | Дорноговь аймаг дахь шүүхийн тамгын газар |
| 24 | 8191           | Д.Пүрэвдорж                  | 2023-02-17 14:00:00 | Иргэний шүүх    | Дорноговь аймаг дахь шүүхийн тамгын газар |
| 25 | 8121           | Дундговь аймгийн засаг дарга | 2023-02-10 14:00:00 | Захиргааны шүүх | Дорноговь аймаг дахь шүүхийн тамгын газар |
| 26 | 8092           | М.Шаравдорж                  | 2023-01-16 14:00:00 | Эрүүгийн шүүх   | Дорноговь аймаг дахь шүүхийн тамгын газар |

### *Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн нэгдсэн системд шүүх хуралдааныг бүртгэсэн байдал*

2.1.10. Шүүхийн иргэдийн төлөөлөгчөөр оролцохын ач холбогдлын талаар иргэдэд ухуулан таниулах ажлыг хэрэгжүүлэх, олон нийтэд сурталчлах

Дорноговь аймгийн Иргэдийн төлөөлөгчийн хурлаас /2023.11.06-11-10/-ны өдрүүдэд Улаанбадрах, Хөвсгөл, Хатанбулаг, Мандах, Сайхандулаан сумуудад,

2023.11.11-15-ны өдрүүдэд Айраг, Даланжаргалан, Иххэт, Дэлгэрэх, Алтанширээ сумуудад зохион байгуулсан ба тус өдөрлөгт Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн гишүүн, 13 байгууллага оролцлоо.

Уг өдөрлөгийн үеэр 400 гаруй иргэдэд шүүхийн ил тод нээлттэй байдлын талаар, шүүхэд хэрхэн мэдүүлэх тухай, шүүхэд нэхэмжлэл, эвлэрүүлэн зуучлалд өргөдөл хэрхэн гаргах, шүүхийн иргэдийн төлөөлөгчөөр сонгогдсон иргэдэд шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлын талаар мэдээлэл өгч QR код бүхий гарын авлага тараан төрийн үйлчилгээг хүргэж ажиллалаа.

Төлөвлөгөөт ажлын дагуу шүүхэд харьяалагдах Дорноговь аймгийн Айраг, Алтанширээ, Даланжаргалан, Дэлгэрэх, Мандах, Иххэт, Сайхандулаан, Сайншанд, Хатанбулаг, Хөвсгөл зэрэг 10 сумын иргэдэд 2023 оны 11 дүгээр сарын 6-13, 20-ны өдрүүдэд шүүхийн Тамгын газраас шүүхийн шүүн таслах ажиллагаа, Шүүхийн иргэдийн төлөөлөгч, Эвлэрүүлэн зуучлах ажиллагааны талаарх сургалтыг зохион байгуулж, мэдээлэл, гарын авлагаар ханган ажиллалаа. Сайншанд суманд зохион байгуулагдсан нээлттэй хаалганы өдөрлөгт тогтмол оролцож байна.



Сайхандулаан сумын мэдээллийн самбарт QR код байршуулав



*Сумдад ажилласан байдал*

#### 2.1.11. ERP Системийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх


Төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны нэгдсэн системийг 2023 оны 04 дүгээр сараас үйл ажиллагаандаа бүрэн нэвтрүүлэн ажиллаж байна. Шүүхийн тамгын газрын бүтэц орон тоог бүртгэж захиргааны 25 албан хаагчид хэрэглэгчийн эрх нээж, хувийн хэрэг, албан тушаалын ангилалд хамаарах хандах эрхийг тохируулж өгсөн.

Албан хаагч өөрт олгогдсон хандах эрхийн хүрээнд ажлын хэсэг байгуулах, албан бичиг боловсруулах, албан бичиг хүлээж авах, явуулах, тайлан судалгаа гаргах гэх мэт программын үндсэн цэсийг өдөр тутмын үйл ажиллагаандаа ашиглаж хэвшсэн.

Тус программыг үйл ажиллагаандаа нэвтрүүлснээр ажил төлөвлөх, багаар ажиллах, үүрэг даалгавар өгч хяналт тавих, мэдээлэл солилцох зохион байгуулалтын арга хэмжээг хялбарчилж байна.

### 2.2.1. Төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны нэгдсэн ERP системийг нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах, үйл ажиллагааг жигдрүүлэх


Төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны нэгдсэн системийг 2023 оны 04 дүгээр сараас үйл ажиллагаандаа бүрэн нэвтрүүлж 2023 оны 09 дүгээр сарын 29-ний өдөр Шүүхийн Ерөнхий зөвлөлөөс ерөнхий шүүгч нар, тамгын газрын даргад ирүүлсэн тоон гарын үсгийн токен төхөөрөмжийг ашиглан албан бичигт цахим гарын үсэг зурах, албан бичиг солилцох, дотоод үйл ажиллагаанд шилжилт хөдөлгөөн бүртгэх, мэдээлэл дамжуулах, бичиг танилцуулах, ээлжийн амралт, томилолт, цаг бүртгэх, чөлөө олгох зэрэг үйл ажиллагааг жигдрүүлэн өдөр тутмын үйл ажиллагаандаа ашиглаж байна.



*Шүүхийн захиргааны ажилтнуудын ээлжийн амралтыг тухай бүр бүртгэж байна.*

*Бусад төрийн байгууллагад 16 удаа бичиг хүргүүлсэн байна.*


*Erp системээр 267 бичиг бусад хэлбэрээр ирсэн 107 шүүгч, шүүхийн захиргааны танилцууллаа.*



*хүлээн авч, бичгийг бүртгэж албан хаагчид*



*Erp e-chat аппликейшныг ашиглан ажлын цагийг бүртгэж албан хаагчдын ажлын цаг ашиглалтад хяналт тавин*



*ажиллаж байна.*

## 2.2. Мэдээллийн хэргийн хөдөлгөөний

**технологи,**

## удирдлагыг хэрэгжүүлэх

### 2.2.2. Шүүхийн дотоод сүлжээний зохион байгуулалтыг сайжруулах

Улирал бүр шүүгч, захиргааны ажилтанд шүүхийн сургалтыг зохион байгуулж тухай бүр мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажилласан.

Дорноговь аймаг дахь Шүүхийн тамгын газрын захиргааны ажилтнуудад Тагнуулын ерөнхий газрын Дорноговь аймаг дахь хэлтсийн ажилтан О.Эрдэнэ-Очирыг урьж “Кибер аюулгүй байдлын өнөөгийн нөхцөл байдал” сэдэвт сургалт зохион байгууллаа.



Шүүхийн дотоод болон гадаад сүлжээнд өдөр тутам хяналт тавьж ажиллаж байгаа бөгөөд гэмтэл гарсан бол тухай бүрд нь засварлаж ажиллаж байна. 2023 оны бүтэн жилийн байдлаар шүүхийн сүлжээнд гарсан гэмтэл доголдолгүй бөгөөд гаднын халдлагад өртөж шүүн таслах ажиллагааг тасалдуулсан тохиолдол гаргаагүй байна. Мэдээллийн аюулгүй байдлаар болон мэдээллийн технологийн талаарх зөвлөмж мэдээллийг тухай бүрд нь шүүгч, шүүхийн захиргааны ажилтнуудад тогтмол өгч ажиллаж байна.

### 2.2.3. Шүүх, шүүхийн захиргааны үйл ажиллагаанд мэдээллийн технологийн инновац нэвтрүүлэх



Иргэдэд архивын үйлчилгээг түргэн шуурхай үзүүлэх зорилгоор ККТТ-тай 2023 оны 07 дугаар сарын 06-ны өдөр 230706/08 дугаар гэрээ байгуулан архивын үйлчилгээний төлбөрийг Qpay

үйлчилгээг ашиглан шүүхийн байрнаас төлөх боломжийг бүрдүүллээ. Ингэснээр

иргэдэд чирэгдэл бага, бага мөнгөн дүнгээр төлбөр тооцоо хийхээр банканд очих шаардлагагүйгээр шүүхийн байрнаас үйлчилгээг авах боломжтой юм.

*Дээрх үйлчилгээг 2023 оны 09 дүгээр сарын 18-ны өдрөөс эхлэн ашиглаж байгаа бөгөөд 13 удаа архивын үйлчилгээний төлбөр төлөхөд ашигласан байна.*



Дорноговь аймаг дахь шүүхийн тамгын газрын цахим веб хуудас руу QR кодыг уншуулан мэдээлэл авах боломжтой

Иргэний хэргийн эвлэрүүлэн зуучлалд кодыг уншуулан



анхан шатны шүүх дэх өргөдөл гаргах тохиолдолд QR өргөдөл гаргах боломжтой.



Иргэний хэргийн анхан шатны шүүхэд нэхэмжлэл гаргахад QR кодыг иргэд уншуулан нэхэмжлэлээ гаргах боломжтой.



Шүүхийн иргэдийн ойлголт мэдээллийг сонгогдсон иргэн QR боломжтой.



төлөөлөгчийн эрх зүйн байдлын шүүхийн иргэдийн төлөөлөгчөөр кодыг уншуулан мэдээлэл авах

2.2.4. Хэргийн хөдөлгөөний удирдлагын e-case системийн хүсэлтийн тоо, хэрэглэгчийн алдааг багасгах

2022 онд хэрэглэгчийн алдаа 25, системийн алдаа 4 нийт 29 цахим хүсэлт явуулж байсан бол энэ онд хэрэглэгчийн алдаа 12, цахим сангийн хүсэлт 8, системийн алдаа 6 тус тус цахим хүсэлтийг явуулснаар хэрэглэгчийн алдаа өмнөх оныг мөн үетэй харьцуулахад 48 хувиар буурсан үзүүлэлттэй байна.



*E-case  
системээр  
хяналт  
тавьсан  
байдал*

### 2.2.5. Хэргийн хөдөлгөөний удирдлагын чиглэлээр дотоод хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх

Хэргийн хөдөлгөөний удирдлагын хэрэгжилтэд Тамгын газраас өдөр тутам хяналт тавьж, E-case хэргийн хөдөлгөөний нэгдсэн удирдлагын системийн мониторинг цэсээс эрх зүйн актыг баталгаажуулах сүүлийн хугацаа дөхөж байгаа талаар анхааруулж дотоод чатаар мэдээлэл өгч ажилладаг.

Мөн улирал тутам дотоод хяналт шалгалтыг явуулж, дүнг илтгэх хуудсаар шүүхүүдэд хүргүүлж ажиллаж байна.

### 2.2.6. Мэдээллийн технологи, хэргийн хөдөлгөөний удирдлагын чиглэлээр дотоод сургалтыг зохион байгуулах

Шинээр томилогдсон шүүхийн захиргааны ажилтнуудад хэргийн хөдөлгөөний нийтлэг болон түр аргачлал, бүртгэл, хэргийн хөдөлгөөний нийтлэг болон түр аргачлал, бүртгэл, хяналтын нэгдсэн системийн сургалт хэлэлцүүлгийг зохион байгуулж тухай бүр гар бүртгэл, программ дээрх ажиллагааг нь хянан шалгаж хэвшүүлсэн байна.

### 2.2.7. Шүүхийн шийдвэрийг цахим хуудаст холбогдох журмын дагуу байршуулж буй байдалд хяналт тавих

2023 оны 12 дугаар сарын 04-ний байдлаар Shuukh.mn сайтад Дорноговь аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх 83 хэрэг хянан шийдвэрлэснээс 53 магадлалыг, Захиргааны хэргийн анхан шатны шүүх 16 хэрэг хянан шийдвэрлэснээс 16 шийдвэр, Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх нийт 201 хэрэг хянан шийдвэрлэснээс 179 шийтгэх, цагаатгах тогтоол, Иргэний хэргийн анхан шатны шүүх 565 хэргийг хянан шийдвэрлэснээс 31 шийдвэрийг холбогдох журмын дагуу байршуулж ажилласан байна.



## **2.3. Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх**

2.3.1 Шүүхийн иргэдийн төлөөлөгчийг сонгож, шүүх хуралдаанд оролцуулах үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийх, хяналт-шинжилгээний үр дүнг үндэслэн зохих арга хэмжээг авч хэрэгжүүлэх

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 63 дугаар зүйлд заасны дагуу тус шүүхэд бүрэлдэхүүнтэй шийдвэрлэх шүүх хуралдааны тов гармагц "Шүүхийн иргэдийн төлөөлөгчдийн нэгдсэн систем"-ээс санамсаргүй сонгогдсон 10 иргэнээс тухайн шүүх хуралдаанд оролцох иргэдийн төлөөлөгчийг сонгох ажиллагааг хийж сонгогдсон иргэдийн төлөөлөгчийн нэрсийн жагсаалтыг шүүхийн Тамгын газрын даргын тушаалаар баталгаажуулдаг. Тайлант хугацаанд 26 удаа шүүхийн иргэдийн төлөөлөгчийг томилох "Дэд жагсаалт батлах тухай" тушаал гарсан байна.

Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн хөлсийг шүүхийн Ерөнхий зөвлөлийн дарга, Сангийн сайдын 2022 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн 6/А3 дугаар хамтарсан тушаалаар баталсан "Шүүхийн иргэдийн төлөөлөгчид хөлс болон албан томилолт, замын зардал олгох журам"-д заасны дагуу олгон ажиллаж байна. 2023 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар 25 иргэдийн төлөөлөгчид холбогдох журмын дагуу хөлс олгосон бөгөөд аймгийн төвөөс алслагдсан сумаас сонгогдож шүүх хуралдаанд оролцсон иргэдийн төлөөлөгч байхгүй тул замын зардлын баримт бүрдүүлсэн тохиолдол гараагүй байна.

Мөн Шүүхийн иргэдийн төлөөлөгчийг зарлагдсан бүрэлдэхүүнтэй шүүх хуралдаанд шүүх хуралдаан эхлэхээс Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2022 оны 60 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан "Тангаргийн хуудас"-аар иргэдийн төлөөлөгчийг тангараг өргүүлж, тус хуудсыг хавтас хэрэгт хавсаргаж байна.

Иргэдийн төлөөлөгчөөс шалтгаалж шүүх хуралдаан хойшилсон тохиолдол гараагүй болно.

2.3.2. Архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийх, үр дүнг үндэслэн зохих арга хэмжээг авч хэрэгжүүлэх

Дорноговь аймаг дахь шүүхийн тамгын газрын дэргэдэх хөмрөг үүсгэгч архив нь Шүүхийн Ерөнхий зөвлөлийн 2021 оны 10 дугаар сарын 01-ны өдрийн 56 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт Шүүхийн архивын ажиллах журам, Архив

албан хэрэг хөтлөх тухай хууль, Байгууллагын архивын ажиллах журмыг удирдлага болгон ажиллаж байна.

Албан хэрэг хөтлөлтийн журамд заасны дагуу сар бүрийн 28-ны өдөр шүүн таслах ажиллагаатай холбоогүйгээр ирсэн хариутай, хариугүй бичгийн мэдээг 7 хоног бүрээр гаргаж Эрүү, Иргэн, Захиргаа, Давж заалдах шатны шүүхийн Ерөнхий шүүгчид хугацаанд нь тогтмол илтгэх хуудсаар танилцуулж хэвшсэн байна.

ТУС ШҮҮХЭД ИРСЭН АЛБАН БИЧИГ, ӨРГӨДӨЛ ГОМДЛЫН ТАЛААРХ ТАНИЛЦУУЛГА


2023.05.01-05.05

| д/д             | Сар өдөр   | Хаанаас, хэнээс                                     | Товч утга  | Хэнд шилжүүлсэн                    | Шийдвэрлэсэн байдал                                 | Тайлбар    |
|-----------------|------------|---|--|------------------------------------|---|------------|
| 168.            | 2023.05.01 | Шүүхийн ерөнхий зөвлөл                              | Шүүгчид чөлөө олгосон судалгаа ирүүлэх тухай         | АБХЭ<br>Н.Норжинлхамд              | Цахим хаягаар судалгааны хариу хүргүүлсэн.          | 2023.05.02 |
| 92.             | 2023.05.01 | Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүх     | М.Оюу-Эрдэнийг шилжүүлэн ажиллуулах тухай            | -                                  | Тамгын газрын даргад танилцуулсан.                  | 2023.05.01 |
| 93.             | 2023.05.02 | Шүүхийн ерөнхий зөвлөл                              | Шүүх байгуулах тухай хуулийн төсөлд санал авах тухай | Ерөнхий шүүгчийн туслуулахуудад    | Шүүхүүдийн саналыг нэгтгэж цахим хаягаар хүргүүлсэн | 2023.05.05 |
| 94.             | 2023.05.02 | Шүүхийн ерөнхий зөвлөл                              | Эрдэм шинжилгээний өгүүлийн удирдамж хүргүүлэх тухай | Шүүхийн захиргааны ажилчдад        | Шүүхийн захиргааны албан хаагчдад танилцуулсан      | 2023.05.02 |
| 95.             | 2023.05.02 | Нийт шүүгчдийн чуулган зохион байгуулах ажлын хэсэг | Мэдээлэл хүргүүлэх тухай                             | Эвлэрүүлэн зуучлагч<br>О.Батбямбад | Шүүгч нарт танилцуулсан.                            | 2023.05.02 |
| 96.             | 2023.05.03 | Шүүхийн ерөнхий зөвлөл                              | Чиглэл хүргүүлэх тухай                               | АБХЭ<br>Н.Норжинлхамд              | Тамгын газрын даргад танилцуулсан.                  | 2023.05.03 |
| 97.             | 2023.05.03 | Шүүхийн ерөнхий зөвлөл                              | 2024 оны төсвийн хязгаарын санал авах тухай          | Нягтлан<br>Д.Даваахүүд             | 2024 оны төсвийн төсөл хүргүүлсэн.                  | 2023.05.10 |
| 98.             | 2023.05.03 | Аймгийн цагдаагийн газар                            | Шийтгэх тогтоолын хуулбар авах тухай                 | АБХЭ<br>Н.Норжинлхамд              | Хэргээс хуулбарлаж өгөв.                            | 2023.05.03 |
| 99.             | 2023.05.03 | Аймгийн цагдаагийн газар                            | Шийтгэх тогтоолын хуулбар авах тухай                 | АБХЭ<br>Н.Норжинлхамд              | Хэргээс хуулбарлаж өгөв.                            | 2023.05.03 |
| Өргөдөл, гомдол |            |   |  |                                    |   |            |
| 100.            | 2023.05.03 | Б.Баярцацэг   | Хэргээс шүүхийн шийдвэрийн хуулбар авах тухай        | АБХЭ<br>Н.Норжинлхамд              | Хэргээс хуулбарлаж өгөв.                            | 2023.05.03 |
| 101.            | 2023.05.05 | Г.Алтанцэцэг  | Ажилд авсан тушаалын хуулбар авах тухай              | АБХА<br>Н.Норжинлхамд              | Хуулбарлаж өгөв.                                    | 2023.05.09 |
| 102.            | 2023.05.05 | Хан баян буурал чандмань ХХК                        | Тодорхойлолт гаргуулах тухай                         | АБХА<br>Н.Норжинлхамд              | 68 дугаартай албан бичгээр хариу хүргүүлэв.         | 2023.05.09 |

Мэдээ гаргасан: Архив, бичиг хэргийн эрхлэгч  Н.Норжинлхам

**Ирсэн бичиг, өргөдөл, гомдлын талаарх танилцуулга**

2023 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн 100 дугаартай албан бичгээр Аймгийн Засаг даргын тамгын газрын дэргэдэх архивын тасагт хандаж, архивын улсын байцаагчаар нийт 45 төрлийн хэвлэмэл хуудасны эх загварыг MNS 5140-1,2,3:2021 стандартад нийцүүлэн хянан, баталгаажуулсан байна.



Дорноговь аймаг дахь Шүүхийн тамгын газрын даргын 2020 оны 01 дүгэр сарын 10-ны өдрийн А/05 дугаар тушаалаар нярав Д.Цэрэндуламыг хэвлэмэл хуудсыг захиалах, хадгалах, хяналт тавьж олгох ажилтнаар томилжээ.

Тайлант хугацаанд

Дорноговь аймаг дахь Иргэний хэргийн анхан шатны шүүхэд 11792 ширхэг

хэвлэмэл хуудас, Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхэд 15977 ширхэг хэвлэмэл хуудас, Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд 834 ширхэг хэвлэмэл хуудас, Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх 2642 хэвлэмэл хуудас, Шүүхийн тамгын газарт 911 ширхэг хэвлэмэл хуудас нийт 32156 ширхэг хэвлэмэл хуудсыг олгосон байна. Мөн Шүүхийн Ерөнхий зөвлөлийн 2021 оны 10 дугаар сарын 01-ны өдрийн 56 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан Шүүхийн архивын ажиллах журамд заасан 21 маягтыг бүрэн хөтөлж ажиллаж байна.

Тус шүүхийн Тамгын газрын дэргэдэх хөмрөг үүсгэгч архив нь холбогдох хууль, дүрэм журам, стандартад заасны дагуу ажиллаж байгаа эсэхэд шүүхийн Тамгын газрын даргаас өдөр тутмын хяналтыг хэрэгжүүлж, гарсан зөрчил дутагдалд тухай бүр заавар зөвлөгөө өгч ажиллаж байна.

2.3.3. Эрүүгийн болон зөрчлийн хэрэгт хураагдсан хөрөнгө, орлого, эд мөрийн баримтыг хүлээж авах, шийдвэрлэхтэй холбоотой үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийх, үр дүнг үндэслэн зохих арга хэмжээг авч хэрэгжүүлэх

Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Улсын ерөнхий прокурорын 2019 оны 246, А/80 дугаар хамтарсан захирамж, тушаалаар батлагдсан "Эрүүгийн болон зөрчлийн хэрэгт хураан авсан, битүүмжилсэн хөрөнгө, орлого барьцааны мөнгө, эд мөрийн баримтыг шийдвэрлэх журам"-ын 2.5-д заасны дагуу прокуророос түргэн муудах аюултай эд мөрийн баримт болох 7 хар сүүлт зээрийн махыг устгуулахаар холбогдох байгууллагад шилжүүлэх санал ирүүлснийг шийдвэрлэж, Дорноговь аймгийн Сайншанд сумын Засаг даргын тамгын газрын дэргэдэх Орон тооны бус зөвлөлд шилжүүлсэн.

Мэдээлэл лавлагааны ажилтан эрүүгийн 60, зөрчлийн 3 хэргийн 117 эд мөрийн баримтыг хүлээн авахдаа эд мөрийн баримтыг нэг бүрчлэн шалгаж, эрүүгийн хэргийн бүртгэл, хяналтын нэгдсэн системд бүртгэж, эд мөрийн баримт хариуцсан ажилтанд хүлээлгэн өгсөн байна.

Эрүүгийн болон зөрчлийн хэргийг хүлээн авахдаа журмын 3.5-д заасны дагуу 2 металл хайгч, 18 сидиг хэвийн ажиллагаатай эсэхийг шалгаж авч, эд мөрийн баримт хариуцсан ажилтанд хүлээлгэн өгчээ.

2023 онд 2 хэргийн 8 эд мөрийн баримтыг овор хэмжээ болон муудах аюултай эд мөрийн баримтыг шүүхэд хүлээн авах боломжгүй тохиолдолд журамд заасны дагуу хадгалах, хариуцах үүрэг хүлээсэн хүн, хуулийн этгээдийн нэр, хаяг

зэргийг үндэслэн тэмдэглэл үйлдэн, шийтгэх тогтоол хүчин төгөлдөр болмогц шүүхийн шийдвэрт заасны дагуу устгах, буцаан олгох зэрэг ажиллагааг гүйцэтгэж ажиллалаа.

Эд мөрийн баримт хүлээн авсан, шийдвэрлэсэн бүртгэлд мэдээлэл лавлагааны ажилтан эд мөрийн баримтыг хүлээн авсан огноо, хүлээн авсан ажилтны нэр, гарын үсэг, хэргийн индекс, шүүгдэгч, холбогдогчийн нэр, регистрийн дугаар, эд мөрийн баримтын нэр, тоо ширхгийн талаар тодорхой бичдэг ба 2023 онд эрүүгийн 60, зөрчлийн 3 хэргийн 117 эд мөрийн баримтыг журмын дагуу бүртгэж хөтөлсөн байна.

2023 онд эд мөрийн баримт шийдвэрлэх комисс 3 удаагийн байдлаар 29 эрүүгийн хэргийн 64 эд мөрийн баримт, 2 зөрчлийн хэргийн 2 эд мөрийн баримт, нийт 31 хэргийн 66 эд мөрийн баримтыг устгаж, 3 эд мөрийн баримтыг хэргийн оролцогчид буцаан олгосон байна.



*Эд мөрийн баримт устгаж буй байдал*

2.3.4. Шүүхийн хүний нөөцийн программ дахь шүүгч, ажилтны мэдээлэл, хэвийн ажиллагаанд хагас жил тутамд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, үр дүнг үндэслэн зохих арга хэмжээг авч хэрэгжүүлэх

Шүүхийн хүний нөөцийн программ дахь шүүгч, шүүхийн захиргааны ажилтны хувийн хэрэг, бусад мэдээлэлд өөрчлөлт орсон тохиолдолд тухай бүр Шүүхийн хүний нөөцийн программ ашиглах журамд заасан хугацаанд баяжилт хийж ажиллаж байгаа бөгөөд Тамгын газрын дарга сар бүр хяналт шалгалт хийж, илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээ авч ажиллаж байна.

Дорноговь аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны Ерөнхий шүүгчийг Монгол Улсын дээд шүүхийн шүүгчээр томилогдсон талаар Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгчийн сонгон шалгаруулалт, хүний нөөцийн газарт мэдэгдэж шүүхийн хүний нөөцийн программаар шилжилт хийлгэсэн.

2.3.5. Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх үйл ажиллагаанд хяналт шинжилгээ хийх, үр дүнг үндэслэн зохих арга хэмжээг авч хэрэгжүүлэх

Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журмын 2 дугаар зүйлд заасны дагуу шүүгч, ажилтны хувийн хэргийн бүрдлийг бүрэн бүрдүүлэн ажиллаж байна.

Шүүгч ажилтны хувийн хэргийн бүрдлийн товъёгийг 2022 оны 07 дугаар сарын 05-ны өдөр шинэчилсэн бөгөөд 2023 онд шинээр ажилд орсон 5 албан хаагчийн хувийн хэргийг зохих журмын дагуу бүрдүүлэн дотоод товъёг хийсэн.

Тайлант хугацаанд төрийн албанаас чөлөөлөгдсөн 2, өндөр насны тэтгэвэрт гарсан 2 албан хаагчийн хувийн хэргийг эх хувийг албан хаагчид өгч, хуулбар хувийг цахим болон цаасан хэлбэрээр архивлан хадгалж байна.

Төрийн өөр байгууллагад шилжин болон сэлгэн томилогдсон албан хаагчийн ажлыг хүлээлцүүлж, холбогдох тооцоо дууссаны дараа түүний хувийн хэргийг албан бичгээр тухайн байгууллагад шилжүүлж хэвшсэн бөгөөд тайлант хугацаанд өөр байгууллагад шилжин ажилласан 2 албан хаагчийн хувийн хэргийг тухайн байгууллагад шилжүүлсэн.

Шүүгч, шүүхийн захиргааны ажилтны хувийн хэргийн бүрдүүлэлтэд Тамгын газрын дарга хагас жил тутамд хяналт тавьж ажиллаж байна.

#### **2.4. Архив, албан хэрэг хөтлөлтийн чиглэлээр авч хэрэгжүүлж буй үйл ажиллагаа**

2.4.1. Иргэн, хуулийн этгээдээс хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хамаарахгүй асуудлаар ирүүлсэн өргөдөл, гомдлыг хүлээн авч, зохих журмын дагуу хуваарилж, шийдвэрлэлтийн мэдээг сар бүр гаргаж Ерөнхий шүүгчид танилцуулах.

|                     | <b>Захирамж, шийдвэр хуулбарлах</b> | <b>Хавтаст хэргээс баримт хуулбарлах</b> | <b>Төлбөртэй лавлагаа</b> | <b>Хавтаст хэрэгтэй танилцах</b> |
|---------------------|-------------------------------------|--|---------------------------|----------------------------------|
| <b>Хуудасны тоо</b> | 344                                 | 742                                      | 18                        | 4                                |


|  |                |         |         |        |
|--|----------------|---------|---------|--------|
| Үнэ  | 500            | 200     | 10,000  | 5,000  |
| Дүн  | 172,000        | 148,400 | 180,000 | 20,000 |
| QRay үйлчилгээ ашиглан төлсөн төлбөр       | 12,700 төгрөг  |         |         |        |
| Улсын орлогод төвлөрүүлсэн нийт мөнгөн дүн | 520,400 төгрөг |         |         |        |

- Нийт лавлагаа олгосон тоо: 18
- Хуулбар олгосон тоо: Иргэдэд олгосон хуулбарын тоо- 88
- Хуулийн этгээдэд олгосон хуулбарын тоо- 10
- Нийт олгосон хуулбарын тоо-98

Иргэдэд архивын үйлчилгээг түргэн шуурхай үзүүлэх зорилгоор ККТТ-тай 2023 оны 07 дугаар сарын 06-ны өдөр 230706/08 дугаар гэрээ байгуулан архивын үйлчилгээний төлбөрийг Qray үйлчилгээг ашиглан шүүхийн байрнаас төлөх боломжийг бүрдүүллээ. Ингэснээр иргэдэд чирэгдэл бага, бага мөнгөн дүнгээр төлбөр тооцоо хийхээр банканд очих шаардлагагүйгээр шүүхийн байрнаас үйлчилгээг авах боломжтой юм.

Дээрх үйлчилгээг 2023 оны 09 дүгээр сарын 18-ны өдрөөс эхлэн ашиглаж байгаа бөгөөд 13 удаа архивын үйлчилгээний төлбөр төлөхөд ашигласан байна.

*Qray үйлчилгээгээр төлбөр төлсөн*



дансны хуулга

2.4.2 Байгууллагын үйл ажиллагааг баримтжуулах.

Шүүхийн тамгын газарт ирсэн 502 албан бичгээс бусад байгууллага албан тушаалтан, иргэн, аж ахуйн нэгжээс ирүүлсэн 209 хариутай албан бичигт хууль тогтоомжид заасан хугацаанд нь шуурхай хариу өгч, байгууллагын цахим хаягаар ирсэн албан бичиг, мэдээллийг Тамгын газрын даргад танилцуулан холбогдох албан тушаалтанд шилжүүлж, хариу хүргүүлж ажилласан байна.

Шүүхийн тамгын газраас бусад байгууллага, албан тушаалтан, иргэн, аж ахуйн нэгж руу явуулсан 217 албан бичгийг байгууллагын цахим хаягаар болон албан бичгээр хүргүүлсэн байна.

| 2022 оны 12 дугаар сарын 22-ны өдрөөс 2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар |   |                |      | Дүн   |
|--|---|----------------|------|-------|
| д/д  | Шүүхийн нэр   | Явуулсан бичиг | Богц |       |
| 1  | Шүүхийн тамгын газар  | 217            | 1    | 218   |
| 2  | Дорноговь аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх   | 296            | 15   | 311   |
| 3  | Дорноговь аймгийн Захиргааны хэргийн анхан шатны шүүх             | 127            | 8    | 135   |
| 4  | Дорноговь аймаг дахь сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх | 538            | 9    | 547   |
| 5  | Дорноговь аймаг дахь сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүх  | 380            | 10   | 390   |
| 6  | Эвлэрүүлэн зуучлал  | 297            | -    | 297   |
|  | Дүн   | 1,855          | 43   | 1,888 |

2023 оны 11 сарын 30-ны өдрийн байдлаар нийт 1,888 албан бичиг, захидал, илгээмж, богц явуулсан байна.



Явуулсан бичгийн ангилал

| 2022 оны 12 дугаар сарын 22–ны өдрөөс 2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийг хүртэлх судалгаа |   |                               |      | Дүн |
|--|---|-------------------------------|------|-----|
| д/д  | Шүүхийн нэр   | Шуудангаар хүлээж авсан бичиг | Богц |     |
| 1  | Шүүхийн Тамгын газар  | 87                            | 1    | 88  |
| 2  | Дорноговь аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх   | 23                            | 19   | 42  |
| 3  | Дорноговь аймгийн Захиргааны хэргийн анхан шатны шүүх             | 62                            | 8    | 70  |
| 4  | Дорноговь аймаг дахь сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх | 102                           | 8    | 110 |
| 5  | Дорноговь аймаг дахь сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүх  | 348                           | 10   | 358 |
| 6  | Эвлэрүүлэн зуучлал  | 50                            | -    | 50  |
|  | Дүн   | 672                           | 46   | 718 |

2023 оны 11 сарын 30-ны өдрийн байдлаар шуудангаар нийт 718 ширхэг албан бичиг, захидал, илгээмж, богц ирсэн байна.

2.4.3. Захидал харилцаа, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг холбогдох дүрэм, журам, зааврын дагуу зохион байгуулах

Захидал харилцаа, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2021 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн А/222 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Байгууллагын архивын үйл ажиллагааны нийтлэг журам”, Шүүхийн Ерөнхий зөвлөлийн 2021 оны 21 дүгээр тогтоолоор батлагдсан “Иргэн, захиргааны хэргийн баримтын тусгай архивын ажлын заавар”, 2021 оны 56 дугаар тогтоолоор батлагдсан “Шүүхийн архивын ажиллах журам”, 2022 оны 1 дүгээр тогтоолоор батлагдсан “Шүүхийн архивыг цахим хэлбэрт шилжүүлэх журам”, 2022 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн 71 дүгээр тогтоолоор батлагдсан “Шүүхэд албан хэрэг хөтлөх журам” Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Улсын Ерөнхий прокурор, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2019 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн 41, А/03, А/19 дугаартай хамтарсан тушаал,



захирамжаар батлагдсан заавар зэрэг холбогдох дүрэм, журам, зааврын дагуу зохион байгуулан ажилласан болно.


#### 2.4.4. Шуудангийн үйл ажиллагааг шуурхай зохион байгуулах

Шүүхийн “ГИБРИД” шуудангийн үйлчилгээ авах гэрээг 2022 оны 12 дугаар сарын 22-ны өдрөөс эхлэн Дорноговь шуудангийн үйлчилгээний газартай байгуулан хамтран ажиллаж байна.

Шүүхийн Ерөнхий зөвлөлөөс Монгол шуудан ХК-тай байгуулсан 2023 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн “Шүүхийн гибрид шуудангийн үйлчилгээ авах гэрээ”, 2023 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн “Шуудангийн үйлчилгээ үзүүлэх гэрээ”-г тус тус үндэслэн Монгол шуудан ХК-ийн Дорноговь аймаг дахь төв салбартай хамтран шуудангийн үйлчилгээг хурдан шуурхай зохион байгуулан ажиллах тал дээр анхаарч ажиллаж байна.

Дорноговь аймаг дахь Сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхэд болон шүүх дэх эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд дуудан ирүүлэх тухай 435 мэдэгдэх хуудас, шүүх хуралдааны тов мэдэгдэх 34 мэдэгдэх хуудсыг хүргүүлэн ажилласан байна.

Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээс шүүхэд дуудан ирүүлэх болон шүүх хуралдааны тов мэдэгдэх хуудсыг гибрид шуудангийн үйлчилгээгээр хүргүүлээгүй байна.



*Гибрид шуудангаар мэдэгдэх хуудас хүргүүлсэн байдал*

2.4.5 Архивд хадгалбал зохих хэрэг, баримт бичгийг хүлээн авах, данс, бүртгэл хөтлөх ажлыг зохион байгуулж, баримт нягтлан шалгах орон тооны бус комиссыг Тамгын газрын дэргэд байгуулж ажиллуулах





*Тус шүүхийн Тамгын газрын даргын 2023 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн А/23 дугаар*

тушаалаар “Баримт бичиг нягтлан шалгах комисс”-ыг 5 хүний бүрэлдэхүүнтэйгээр томилсон байна.

2.4.6. Хадгаламжийн нэгжийг хууль, журам, заавар, стандартын дагуу хадгалах, хамгаалах, шүүгч, шүүхийн захиргааны ажилтан, иргэн, хуулийн этгээдэд архивын үйлчилгээ үзүүлэх, тогтоосон хугацаанд үзлэг, тооллого хийх, шилжүүлэх ажлыг зохион байгуулах

Улсын Ерөнхий Прокурорын газрын дэргэдэх Эрүүгийн хэргийн төв архивд 2023 оны 84 хадгаламжийн нэгж хэрэг баримтыг 2023 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн 28 дугаартай албан бичиг, аймгийн Прокурорын газарт 319 хадгаламжийн нэгж хэрэг баримтыг 2023 оны 06 сарын 29-ний өдөр тус тус шилжүүлсэн.


Шүүхийн Тамгын газрын дэргэдэх Хөмрөг үүсгэгч Архивын хэрэг баримтыг цахимжуулах ажлын хэсгийг тус тус байгуулж шүүхийн архивд хадгалагдаж байгаа хэрэг, баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх ажлыг холбогдох хууль, тогтоомжид нийцүүлэн ажиллаж байна.



### Архивын гэрээт ажилтны 7 хоногийн тайланг хүргүүлсэн байдал

Дорноговь аймаг дахь шүүхийн Тамгын газар 2023 онд нийт 7,700 хадгаламжийн нэгжийг цахимжуулсан байна. Архивын баримтыг цахимжуулах ажлыг гэрээт ажилтан гүйцэтгэж байгаа бөгөөд долоо хоног бүрийн Пүрэв гарагт цахимжуулсан баримтыг тоо, мэдээг Шүүхийн Ерөнхий зөвлөлд хүргүүлэн ажиллаж байна.

2.4.7 Шүүхийн Ерөнхий зөвлөлийн даргын 2023 оны 32 дугаар тушаалаар баталсан "Анхан болон давж заалдах шатны шүүхийн архивын баримтад нэгдсэн тооллого явуулах ажлын удирдамж"-ийн дагуу тус шүүхийн Тамгын газрын даргын 2023 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн А/13 дугаартай "Шүүхийн архивын баримтад нэгдсэн тооллого явуулах комисс байгуулах тухай" тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг төлөвлөгөө гарган архивт байгаа 1933-2023 оны хэрэг, баримтыг байнга, түр, 70 жил хадгалах хадгаламжийн нэгжээр ангилж, хуудас тус бүрээр тоолж, нягтлан шалган, илэрсэн зөрчлийг арилгаж 35592 хадгаламжийн нэгж /ХН/ хэрэг, баримтыг бүрэн тоолж, бүртгэлжүүлж дуусгалаа.



Архивын баримтад нэгдсэн тооллого явуулах тухай тушаал

Өмнө нь

Дараа нь





Архивын өрөөг камержуулав

Заавар зөвлөгөөний дагуу архивын өрөөнд гал унтраагуур, усны сав, элсний сав, термометр зэргийг шинэчлэн авч хууль журамд нийцсэний дагуу байрлуулав.



Улсын

Ерөнхий



Прокурорын газрын дэргэдэх Эрүүгийн хэргийн тусгай архивын 2023 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн №89 дугаартай албан бичгийн дагуу, Баримт бичиг нягтлан шалгах комиссын 2023 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн Дорноговь аймаг дахь Шүүхийн тамгын газрын архивд хадгалагдаж байсан 1951-2002 оны Эрүүгийн 1322 хэрэг, 1330 хадгаламжийн нэгжийг 2023 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр Баримт бичиг нягтлан шалгах комиссын дарга шүүгчийн туслах Б.Мөнх-Эрдэнэ, шүүгчийн туслах Б.Бүжмаа, шүүгчийн туслах Я.Эрдэнэ-Уянга, шүүгчийн туслах Д.Золбоо нарын бүрэлдэхүүнтэйгээр нягтлан бодогч Д.Даваахүү, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга Ч.Гандашгүй-Эрдэнэ, бичиг хүргэгч Д.Дандар, жолооч Ч.Баатарчулуун, Р.Батзоригт нарыг оролцуулан Дорноговь аймгийн Сайншанд сумын 4 дүгээр багийн нутаг дэвсгэрт байрлах Улаанбаатар төмөр замын харьяа Барилга орон сууцны 3 дугаар ангийн уурын зууханд шатааж устгасан байна.



### **Дүн шинжилгээ:**

Шүүхийн Тамгын газрын албан хаагчдыг нийгэмд тустай, сайн үйлсийн арга хэмжээнд идэвхтэй хамруулж энэ талаар цахим, сайт, мэдээллийн самбарт байршуулж ажиллалаа.

ERP системийг үйл ажиллагаандаа нэвтрүүлж хууль тогтоомж, дүрэм журам, аргачлал, стандартын нэгдсэн сан бүрдүүлсэн бөгөөд шүүгч, шүүхийн захиргааны ажилтны хоорондын ажил хэргийн харилцааг баримтжуулах, дотоод зохион байгуулалтын үйл ажиллагааг боловсронгуй болгох дэвшил болсон.

Иргэдийн төлөөлөгчөөр сонгогдсон иргэн системээс автоматаар хасагддаг нөөцөд үлдсэн иргэд дахин сонгохоор нэрс нь гарч ирдэг. Иргэдийн төлөөлөгчөөр сонгогдсон иргэд гадаад улсад зорчсон, нас барсан, шилжсэн тохиолдолд системээс хасах боломжгүй байдаг. Иймд системд хасалт хийх, мэдээлэл засварлах боломжтой болгох шаардлагатай байна.

## **ГУРАВ. ШҮҮХИЙГ ХҮНИЙ НӨӨЦӨӨР ХАНГАХ**

3.1. Шүүхийн ерөнхий зөвлөлийн болон төрийн албаны хүний нөөцийн программын бүртгэл хөтлөлтийг тухай бүр бүрэн хийж, шүүхийн Тамгын газрын ажилтны хүний нөөцийн шилжилт хөдөлгөөнийг бүртгэх, хүний нөөцийн мэдээллийн санг баяжуулах, тайланг заасан хугацаанд ирүүлэх

Төрийн албаны зөвлөлийн “Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо” цахим системд 2023 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар тус шүүхэд ажиллаж байгаа нийт 36 албан хаагч бүртгэлтэй байна. Үүнээс 4 шүүхийн захиргааны ажилтан жирэмсний болон хүүхэд асрах чөлөөтэй байгаа болно.





3.3. Монгол Улсын шүүхийн тухай хууль болон Төрийн албаны хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж, сул орон тоог нөхөх ажлыг зохион байгуулах

Монгол Улсын шүүхийн тухай хууль, Төрийн албаны тухай /Шинэчилсэн найруулга/ хууль, түүнтэй холбогдуулан гаргасан дүрэм журмын хүрээнд Шүүхийн Ерөнхий зөвлөлөөс баталсан орон тооны хязгаарт хүргэж ажиллах бодлого баримталж сул орон тоонд томилох, чөлөөлөх, хөдөлмөрийн гэрээ байгуулах, хөдөлмөрийн гэрээ цуцлах, жирэмсний болон хүүхэд асрах чөлөө олгох, сэлгэн, шилжин ажиллуулах зэрэг 34 тушаал гаргаж, хэрэгжилтийг хангаж ажиллаа.

### **Шүүхийн бүтэц орон тоо**

Дорноговь аймаг дахь шүүх нь тайлант хугацаанд дараах бүрэлдэхүүнтэйгээр чиг үүргээ хэрэгжүүлж ажиллалаа. Үүнд:

- Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх-2 шүүгчтэй /Ерөнхий шүүгч Н.Батчимэг нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2023 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн 128 дугаар зарлигаар Монгол Улсын дээд шүүхийн шүүгчээр томилогдсон/;
- Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх-3 шүүгч;
- Иргэний хэргийн анхан шатны шүүх-3 шүүгч /шүүгч Б.Гончигсумлаа Шүүхийн Ерөнхий зөвлөлийн 2022 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн 317 дугаар тогтоолоор Хан-Уул дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд сэлгэн ажиллаж байна/
- Захиргааны хэргийн анхан шатны шүүх- 3 шүүгч / шүүгч С.Отгонтуяа Шүүхийн Ерөнхий зөвлөлийн 2023 оны 09 дүгээр сарын 21-ний өдрийн 246 дугаар тогтоолоор Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд сэлгэн ажиллаж байна/
- Дорноговь аймаг дахь шүүхийн Тамгын газар
  - Тамгын газрын дарга-1
  - Шүүхийн зохион байгуулалт хариуцсан мэргэжилтэн-1
  - Мэдээлэл лавлагааны мэргэжилтэн-1
  - Шүүгчийн туслах-7
  - Шүүх хуралдааны нарийн бичгийн дарга-3
  - Эвлэрүүлэн зуучлагч-1
  - Эвлэрүүлэн зуучлагчийн туслах-1
  - Ахлах нягтлан бодогч-1



- Бичиг хүргэгч-1
- Нярав-1
- Жолооч-2
- Үйлчлэгч-2

Нийт 11 шүүгч, 22 шүүхийн захиргааны ажилтантай үйл ажиллагаа явуулж байна.

**2023 онд дэвшин ажилласан албан хаагчид:**

- Эвлэрүүлэн зуучлагчийн туслах ажилтан Ч.Гандашгүй-Эрдэнэ шүүх хуралдааны нарийн бичгийн даргын албан тушаалд;
- Архив бичиг хэргийн эрхлэгч Н.Норжинлхам шүүхийн зохион байгуулалт хариуцсан мэргэжилтний албан тушаалд;
- Эвлэрүүлэн зуучлагч О.Батбямба мэдээлэл лавлагааны мэргэжилтны албан тушаалд;
- Шүүх хуралдааны нарийн бичгийн дарга Ж.Одтуяа шүүгчийн туслахын албан тушаалд;
- Шүүх хуралдааны нарийн бичгийн дарга Э.Лхагвасүрэн шүүгчийн туслахын албан тушаалд;
- Эвлэрүүлэн зуучлагчийн туслах Г.Хосбаяр шүүх хуралдааны нарийн бичгийн даргын албан тушаалд;
- Архивын гэрээт ажилтан Ё.Мөнхсайхан эвлэрүүлэн зуучлагчийн туслах ажилтнаар тус тус томилогдсон.

**2023 онд албан тушаалаас чөлөөлөгдсөн албан хаагчид:**

- Шүүх хуралдааны нарийн бичгийн дарга Д.Золбоо эрүүл мэндийн шалтгаанаар түр;
- Шүүгчийн туслах Я.Эрдэнэ-Уянга эрүүл мэндийн шалтгаанаар түр;
- Үйлчлэгч Б.Дэлгэрмөнх өндөр насны тэтгэвэрт тогтоолгох насанд хүрч өөрийн хүсэлтээр тус тус чөлөөлөгдсөн.

**2023 онд шилжин ажилласан албан хаагчид:**

- Шүүгчийн туслах Б.Баярмаа Орхон аймаг дахь шүүхийн Тамгын газарт;
- Мэдээлэл лавлагааны мэргэжилтэн А.Бадрал Дорноговь аймгийн Засаг даргын тамгын газарт тус тус шилжин ажиллаг байна.

Шүүхийн захиргааны ажилтны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 2023 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр баталж, 06 дугаар сарын 15-ны өдөр тайлан, үнэлгээг холбогдох

журмын дагуу хагас жилийн байдлаар үнэлж 40-80% үр дүнгийн урамшуулал олголоо.

Төрийн албаны тухай хууль, Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 25 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж, Шүүхийн ерөнхий зөвлөлийн дэргэдэх Салбар зөвлөлд 2023 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 111, 2023 оны 09 дүгээр сарын 22-ны өдрийн 154, 2023 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 171 дугаартай албан бичгээр шүүгчийн туслах 2, мэдээлэл лавлагааны мэргэжилтэн 1, мэдээлэл технологийн мэргэжилтэн 1, шүүхийн үйлчилгээний хэлтсийн дарга 1 сул орон тооны захиалгыг хүргүүлж, олон нийтэд мэдээлэлж ажиллалаа.

Үүнээс 2023 оны 06 дугаар сарын 29-ний өдөр зохион байгуулсан төрийн албаны тусгай шалгалтад тэнцэж хамгийн өндөр оноо авсан Н.Норжинлхамыг шүүхийн зохион байгуулалт хариуцсан мэргэжилтний албан тушаалд томилж, 2023 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр зохион байгуулсан тусгай шалгалтад тэнцэж хамгийн өндөр оноо авсан А.Баяржаргалыг шүүгчийн туслахаар, О.Батбямбыг мэдээлэл лавлагааны мэргэжилтнээр томилохоор Авлигатай тэмцэх газарт хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянуулахаар хүргүүлээд байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 235 дугаар зарлигаар Дорноговь аймаг дахь Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгч Н.Адъяа нь өндөр насны тэтгэвэрт гарах эрх үүсэж, өөрөө хүсэлтээ гаргасан тул шүүгчийн албан тушаалаас чөлөөлөгдсөн байна.

Тус шүүхийн тамгын газар “Хүндэтгэлийн хуралдаан”-ыг 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдөр зохион байгуулсан ба “Хүндэтгэлийн хуралдаан”-д Дорноговь аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн Ерөнхий шүүгч, шүүгчид, Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгч, шүүгчид, Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч, Иргэний хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгч, шүүгчид, хамтран ажилладаг төрийн байгууллагуудын төлөөллүүд болон шүүхийн тамгын газрын хамт олон, гэр бүлээс нь оролцлоо.





### Шүүгчид хүндэтгэл үзүүлэх арга хэмжээ



Аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газраас уламжлан болгон зохион байгуулдаг “Хөдөлмөрийн яармаг”- 2023 оны арга хэмжээнд Шүүхийн зохион байгуулалт хариуцсан мэргэжилтэн Н.Норжинлхам оролцож ажил хайгч иргэдтэй уулзан ажлын байрны сул орон тооны талаар мэдээлэл хүргэж ажиллалаа.

*Шүүхийн тамгын газарт зарлагдсан сул орон тооны болон түр орлон гүйцэтгэгчээр ажиллуулах зарыг шүүхийн Тамгын газрын веб сайт болон цахим хуудсанд тухай бүр байршуулж олон нийтэд мэдээлэл хүргэсэн.*



**Шүүгчийн тангараг өргүүлэх ажлыг зохион байгуулах ажлын хүрээнд:**

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн 88 дугаар зарлигаар Б.Одбаяр Дорноговь аймаг дахь шүүхийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд томилогдлоо.

2023 оны 07 дугаар сарын 19-ний өдөр Шүүгчийн тангараг өргөх ёслолын ажиллагааг зохион байгуулсан байна.



*Шүүгчийн тангараг өргөх ёслолын арга хэмжээ*

3.4. Шүүхийн захиргааны ажилтны сургалтын төлөвлөгөөг холбогдох бодлогын баримт бичиг, онол, практикт тулгуурлан боловсруулж, хэрэгжүүлэх

Цагдаагийн байгууллагаас 2023 онд гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх чиглэлээр хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах зорилгоор “ГОВИЙН БҮС”-ийн гэмт хэргийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, хэргийн илрүүлэлтийн шийдвэрлэлтийг ахиулах, тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх зорилгоор зохион байгуулсан бүсийн сургалт, зөвлөгөөнд Дорноговь аймаг дахь Сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгч Ж.Байгалмаа оролцож “Эрүүгийн хэргийн шийдвэрлэлт, цаашид анхаарах асуудал” сэдвээр мэдээлэл хийж, санал солилцсон ба зөвлөгөөнд Говьсүмбэр, Дундговь, Дорноговь, Өмнөговь аймгуудын Шүүх, Прокурор, цагдаагийн газар, хэлтсийн мөрдөн байцаах тасгийн алба хаагчид болон эрх бүхий алба хаагчид оролцлоо.



2023 оны 05 дугаар сарын 08-ны өдөр Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн Тамгын газрын дарга Д.Өнөржаргалын “Хувь хүний зан төлөв” сэдэвт;

Сонгинохайрхан дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Т.Ариунболдын “Шинэчлэлийн нөлөө” сэдэвт сургалтад Дорноговь аймаг дахь Шүүхийн тамгын газрын захиргааны ажилтнууд хамрагдаж, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх, Сонгинохайрхан дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхүүдийн үйл ажиллагаатай танилцаж, туршлага судаллаа.



*Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд*

Орон нутаг дахь төрийн албан хаагчдад зориулсан "Алсын хараа 2050" Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого, түүний эхний үе шат "шинэ сэргэлтийн

бодлого"-ыг

хэрэгжүүлэхэд

төрийн албан хаагч,

иргэдийн оролцоог

нэмэгдүүлэх нь”

сургалт Алсын

Хараа-2050 болон

Шинэ сэргэлтийн



бодлого, төлөвлөлт, хэрэгжилт, үнэлгээ сэдвийн дор 2023 оны 3 сарын 25-26-ны өдөр зохион байгуулагдаж шүүгчийн туслах Б.Бүжмаа,Э.Эрдэнэ-Уянга нар тус тус хамрагдав.

Шүүхийн ерөнхий зөвлөлөөс 2023 оны 04 дүгээр сарын 27-28-ны өдрүүдэд зохион байгуулсан “Шүүгчийн туслах нарт зориулсан мэргэшүүлэх сургалт”-д шүүгчийн туслахын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч А.Баяржаргал;



хамрагдсан байна.

Шүүхийн ерөнхий зөвлөлөөс 2023 оны 04 дүгээр сарын 20-21-ний өдрүүдэд зохион байгуулсан Шүүх хуралдааны нарийн бичгийн дарга нарын эзэмшвэл зохих суурь мэдлэг, чадварыг гүнзгийрүүлэх сургалтад шүүх хуралдааны нарийн бичгийн дарга Ч.Гандашгүй-Эрдэнэ

Амьдрах урлагийн багш Т.Баясгаланбаатар шүүхийн нийт шүүгч, ажилтанд “Стресс” сэдвээр сургалт зохион байгуулж, ажлын ачааллаас үүдэлтэй бухимдал стрессийг хэрхэн багасгах, арилгах аргаас суралцан, дасгал ажиллаж, харилцан яриа өрнүүллээ.



*Сургалтын явц*

“Нийт шүүгчийн II чуулган” Улаанбаатар хотноо Монголын хүүхдийн ордонд 2023 оны 09 дүгээр сарын 28-29-ний өдрүүдэд зохион байгуулагдаж Дорноговь аймаг дахь шүүхийн 8 шүүгч танхимаар оролцож, 4 шүүгч цахимаар оролцлоо.



Шүүхийн ерөнхий зөвлөлөөс 2023 оны 09 дүгээр сарын 28-ны өдөр шүүхийн захиргааны ажилтны “Шүүх эрх мэдлийн хөгжлийн бодлого” сэдэвт хэлэлцүүлэг зохион байгуулсан ба хэлэлцүүлэгт Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын алба, Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэн, Шүүхийн сахилгын хороо, бүх шатны шүүхийн тамгын газрын нийт 800 албан хаагч чуулж, салбарын хөгжлийн бодлогоо хэлэлцсэн. Уг хэлэлцүүлэгт Дорноговь аймаг дахь Шүүхийн тамгын газрын захиргааны ажилтнууд оролцлоо.

Шүүхийн ерөнхий зөвлөлөөс 2023 оны 10 дугаар сарын 19-21-ний өдрүүдэд зохион байгуулсан нийслэл болон орон нутгийн шүүхийн тамгын газрын



захиргааны ажилтнуудад зориулсан Хууль хэрэглээний сургалтад Шүүх хуралдааны нарийн бичгийн дарга Э.Лхагвасүрэн хамрагдлаа.





Шүүхийн ерөнхий зөвлөлөөс 2023 оны 11 дүгээр сарын 02-ны өдөр Говьсүмбэр аймагт зохион байгуулсан “Шүүхийн захиргааны ажилтны ажлын байран дахь сургалт”-нд Дорноговь, Төв аймаг дахь анхан болон давж заалдах шатны шүүх, Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь сум дундын шүүхийн Тамгын газрын нийт 36 захиргааны ажилтан хамрагдсан ба Дорноговь аймаг дахь шүүхийн Тамгын газрын 8 захиргааны ажилтан оролцсон байна.



3.5. Шүүгч, шүүхийн захиргааны ажилтанд зэрэг дэв олгох, түүнийг төрийн шагнал, хүндэт цолд тодорхойлох асуудлыг хууль тогтоомжийн дагуу хүргүүлэх, уламжлах, шийдвэрлүүлэх

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.1.8 дахь заалт, Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2022 оны 20 дугаар тогтоолоор баталсан “Шүүхийн шагналын журам”-ын 9 дүгээр хэсгийн 9.2-д “...шагналд нэр дэвшүүлсэн материал, холбогдох баримт бичгийг жил бүрийн 02 дугаар сарын 01-ний өдрийн дотор Шүүхийн ерөнхий зөвлөлд цахим, эсхүл цаасан хэлбэрээр ирүүлсэн байна” гэж заасны дагуу 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 13 дугаар албан бичгээр Төрийн дээд одон медаль болон салбарын шагналд нэр дэвшсэн шүүгч, шүүхийн захиргааны ажилтнуудын шагналын материалыг хүргүүллээ.

Тайлангийн хугацаанд шүүхийн байгууллагад олон жил, тасралтгүй, үр бүтээлтэй ажиллаж, эрхэлсэн ажилдаа амжилт гарган ажилласан жолооч Р.Батзоригт “Хөдөлмөрийн хүндэт медаль”-аар;

Дорноговь аймаг дахь шүүхийн Тамгын газар шүүгчийн туслах Э.Болорцэцэг Монгол Улсын дээд шүүхийн “Жуух бичиг”-ээр;

Эвлэрүүлэн зуучлагч О.Батбямба Шүүхийн Ерөнхий зөвлөлийн “Жуух бичиг”-ээр тус тус шагнагдсан байна.



Шүүхийн Ерөнхий зөвлөлийн даргын 2023 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн 39 дугаартай тушаалаар Шүүх хуралдааны нарийн бичгийн дарга Э.Лхагвасүрэнд төрийн захиргааны Дэс түшмэлийн дөтгөөр зэрэг дэвийг шинээр олголоо.

Шүүгчийн туслахын үүргийг түр орлон гүйцэтгэгч А.Баяржаргал нь 2023 оны 06 дугаар сарын 12-ны өдөр шүүхийн захиргааны албан хаагчдад “ШҮҮГЧИЙН ТУСЛАХ НАРТ ЗОРИУЛСАН МЭРГЭШҮҮЛЭХ СУРГАЛТ” сэдвээр сургалт зохион байгууллаа.



2023 оны 06 дугаар сарын 30-ны өдөр Дорноговь аймаг дахь Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн туслах М.Оюу-Эрдэнэ шүүхийн захиргааны албан хаагчдад “Эрүүгийн эрх зүйн бодлого бодох аргачлал” сэдвээр дотоод сургалт зохион байгууллаа.



3.6. Шүүхийн Тамгын газрын дэргэдэх Ёс зүйн зөвлөлийн журамд шүүхийн захиргааны ажилтны ёс зүйн хэм хэмжээ зөрчигдөхөөс сэргийлэх, соён гэгээрүүлэх ёс зүйн сургалт зохион байгуулах

Тус шүүхийн тамгын газрын даргын 2023 оны 01 дүгээр сарын 12-ны өдөр Ёс зүйн зөвлөлийн 2023 онд хийх ажлын төлөвлөгөөг баталсан байна.

Уг төлөвлөгөөний дагуу тамгын газрын дэргэдэх Ёс зүйн зөвлөл нь албан хаагч нарт 6 сургалт, шинээр томилогдсон албан хаагч нарт тухай бүрд нь сургалт зохион байгуулж ажиллалаа. Тайлант хугацаанд ёс зүйн зөрчил гаргасан албан хаагч байхгүй болно.


2023 оны 05 дугаар сарын 10-ны өдөр Дорноговь аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн туслах Э.Болорцэцэг шинээр томилогдсон

Дорноговь аймаг дахь шүүхийн Тамгын газар албан хаагчдад “Шүүхийн захиргааны ажилтны эрх зүйн байдал” сэдвийн хүрээнд төрийн албаны ерөнхий ойлголт, зарчим, албан тушаалын чиг үүргийн талаар сургалт зохион байгууллаа.


“Ёс зүйн зөрчил үйлдэгдэхээс урьдчилан сэргийлэх”, “Ажлын цаг ашиглалт, цагийн менежмент” сэдвээр шүүгчийн туслах Э.Болорцэцэг сургалт зохион байгуулсан ба шинээр томилогдсон албан хаагчид хамрагдлаа.



2023 оны 03 дугаар сарын 28-ны өдөр Дорноговь аймаг дахь Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн, шүүгчийн туслах Я.Эрдэнэ-Уянга тус шүүхийн захиргааны ажилтнуудад “Шүүхийн захиргааны ажилтны ажлын байранд дагаж мөрдөх харилцаа, хандлага”, “Шүүхийн ажилтны ёс зүйн дүрэм” сэдвээр дотоод сургалтыг зохион байгууллаа.



Мөн 2023 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр Ёс зүйн зөвлөлийн гишүүн Э.Лхагвасүрэн “Жендерийн талаарх ойлголт”, “Авлигын эсрэг хууль” сэдвээр сургалт зохион байгуулсан ба уг сургалтад шүүхийн Тамгын газрын ажилтнуудыг хамруулан сургалтын талаарх үнэлгээ хийлгэж, санал авсан нь цаашид авах сургалтын хэрэгцээг тодорхойлоход чухал ач холбогдолтой гэж үзлээ. Санал өгсөн ажилтнуудын дийлэнх нь хувь хүний хөгжлийн талаар сургалтыг авах хэрэгцээтэй байна гэж тодорхойлсон байна.



### Дүн шинжилгээ

Шүүхийг хүний нөөцөөр хангах чиг үүргийн хүрээнд Төрийн албаны тухай хууль болон Монгол Улсын шүүхийн тухай хуулийг дагаж мөрдөн албан хаагч шинээр томилох, шатлан дэвшүүлэх арга хэмжээ авч шүүхийн ерөнхий зөвлөлөөс баталсан орон тооны хязгаарт хүргэж ажиллах бодлого баримталж ажиллалаа.

Мэдээлэл технологийн мэргэжилтэн албан тушаалаас 2022 онд чөлөөлөгдсөн. Одоогоор Мэдээлэл лавлагааны мэргэжилтэн хавсран гүйцэтгэж байгаа учир мэргэжлийн түвшинд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөхөд учир дутагдалтай байдаг. Харин гарын авлагаас өөрийн боломжоор судлан техник хэрэгслийн хэвийн үйл ажиллагааг ханган ажиллаж байна. Мэдээлэл технологийн мэргэжилтэн сул орон тоог нөхөх тусгай шалгалтад иргэд бүртгүүлдэггүй, IT мэргэжилтэй төгсөгчдийг урьж ажлын байр санал болгоход ерөнхий шалгалт өгөхөөс төвөгшөөдөг, мөн төрийн үйлчилгээний ангилалд авч ажиллуулж байгаа байгууллага, эсвэл гэрээний үндсэн дээр ажиллах байгууллагатай хамтрах хандлагатай байдаг.

### ДӨРӨВ. ШҮҮГЧИЙН ХАРААТ БУС БАЙДЛЫГ ХАНГАХ, ХУУЛЬ ЁСНЫ АШИГ СОНИРХЛЫГ ХАМГААЛАХ


4.1. Шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдалд халдсан, алдагдуулсан шинжтэй шийдвэр гаргасан, эсхүл үйл ажиллагаа явуулсан, шүүгчийн эрх ашгийг зөрчсөн тохиолдолд шуурхай арга хэмжээ авах


Шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдалд халдсан, алдагдуулсан шинжтэй үйл ажиллагаа явуулсан тохиолдол байхгүй болно.

#### 4.2. Шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг Цагдаагийн байгууллагатай хамтран тухай бүр зохион байгуулах

Шүүхийн тамгын газраас 2023 онд шүүгч, шүүх бүрэлдэхүүн нүүдэллэн ажиллах үеийн аюулгүй байдлыг хангаж ажиллах тухай 21 албан бичиг Аймгийн цагдаагийн газарт хүргүүлж, цагдаагийн албан хаагч шүүгч, шүүх бүрэлдэхүүнийг томиллолтоор ажиллах үеийн аюулгүй байдлыг хангаж ажилласан байна.

Шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах үүднээс Шүүхийн хамгаалалтын бүсийг баталгаажуулж, галын аюулгүй байдлын дүгнэлтийг гаргуулж ажиллалаа.





Шүүх, шүүхийн барилга байгууламжийн аюулгүй байдлыг хангаж, 24 цагаар харуул хамгаалалтад ажилласан. Шүүхийн тамгын газрын дарга өдөр бүр хамгаалалтын цагдаатай уулзаж, рапортын дэвтэртэй танилцан, хяналт тавьж ажиллаж байна.

Шүүхийн байранд нийт 3650 иргэнийг журмын дагуу шалгаж, бүртгэл хөтлөн шүүхийн байранд нэвтрүүлж ажиллалаа.




*Шүүхийн цагдаагийн хөтөлдөг бүртгэлийн дэвтэр*





Шүүхийн байрны гадна дотор 24 хяналтын камер ажиллаж байна.

Шүүхийн тамгын газраас ажлын бус цагаар ажиллах албан хаагчийн нэрсийг өдөр бүр шүүхийн хамгаалалтын цагдаад цахимаар өгч хэвшсэн.



*Ажлын бус цагаар ажиллах албан хаагчдын нэрс хүргүүлсэн байдал*

Мөн архивын өрөө, хэргийн эд мөрийн баримт хадгалах өрөө, серверийн өрөө болон бусад өрөө тасалгааг түгжиж, лацдаж хүлээлгэн өгч, өдөр тутмын хяналт тавьж ажиллаж байна.





Өрөөний хаалга лацадсан  
байдал



“Билгийн тооллын хаврын тэргүүн сар-Цагаан сарын баяр”, “Хүүхдийн баяр” бусад тэмдэглэлт баяр, бүх нийтийн амралтын өдрүүдэд тухай бүр арга хэмжээ зохион байгуулж, Дорноговь аймаг дахь шүүх дээр сахилга хариуцлага, дэг журам, сонор сэрэмжийг өндөржүүлэх зорилгоор Тамгын газрын даргын 2023 оны А/09, А/11, А/22, А/29, А/39 дугаар тушаалаар хариуцлагатай жижүүр, эргүүлээр 11 ажилтныг томилон ажиллуулжээ.



Шүүх хуралдаанд оролцогчдын гар утас, дуу, дуу дүрсний бичлэг хийх төхөөрөмж зэргийг дэг сахиулагч унтраалган, хураан авч, гар утас хадгалах шүүгээнд хадгалж, шүүх хуралдаан дууссаны дараа буцаан олгож байна.

#### **4.3. Шүүхийн тамгын газар, Цагдаагийн байгууллагатай хамтран ажиллах төлөвлөгөө батлах, хэрэгжилтийг хангаж ажиллах**

Дорноговь аймаг дахь Шүүхийн тамгын газар, Дорноговь аймгийн Цагдаагийн газартай 2023 онд хамтран ажиллах төлөвлөгөөг боловсруулан, 2023 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр баталсан. Уг төлөвлөгөөнд 3 чиглэлээр 19 ажил

төлөвлөсөн ба хамтран ажиллах төлөвлөгөөний хэрэгжилт 94,8 хувьтай байна. Хийгдсэн ажлаас дурдвал:

Эрүүгийн анхан шатны шүүхийн 425, Эрүүгийн давж заалдах шатны шүүхийн 50, зөрчлийн 437, Захиргааны хэргийн 29, Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 385, иргэний хэргийн Давж заалдах шатны шүүхийн 32 нийт 1370 шүүх хуралдаанд шүүх хуралдааны дэг журам сахиулж ажилласан байна.

2023 оны байдлаар шүүхээс цагдан хорих байр руу 193 удаа, цагдан хорих байрнаас шүүх рүү 159 удаа яллагдагчийг хуяглан хүргэсэн байна.

Цагдаагийн байгууллагын эрэн сурвалжлах ASAP санд бүртгэгдсэн Дорноговь аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд нийт 82 иргэнийг эрэн сурвалжилснаас 70 иргэнийг олж тогтоон зохих журмын дагуу шийдвэрлэж ажилласан. Үүнээс Дорноговь аймаг дахь Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх, Иргэний хэргийн анхан шатны шүүхээс нийт 32 эрэн сурвалжлуулах тухай шийдвэр ирүүлсний 25 иргэнийг олж тогтоон, 7 иргэнийг эрэн сурвалжлах ажиллагаа явагдаж байна.

Мөн анхан шатны шүүхээс албадан ирүүлэх 25 захирамж ирүүлснээс 25 иргэнийг албадан ирүүлээд байна. Төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу хийгдээгүй ажлуудыг онд багтаан хийхээр төлөвлөөд байна.

4.4. Шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах талаар Цагдаагийн байгууллагатай хамтарсан уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулж хэвших

Цагдаагийн байгууллагатай хамтран ажиллах төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах талаар хамтарсан 2023 оны 01 сарын 09-ний өдөр Дорноговь аймгийн Цагдаагийн Нийтийн хэв журам хамгаалах тасгийн ахлах байцаагч, цагдаагийн ахлах дэслэгч Б.Баярхүү, Нийтийн хэв журам хамгаалах тасгийн ахлах байцаагч, Цагдаагийн ахлах дэслэгч О.Ууганбаатар хамгаалалтын цагдаа нарыг оролцуулан зөвлөгөөнийг зохион байгууллаа.



2023.01.09

Уг зөвлөгөөнөөр “Шүүх хуралдааны дэг сахиулах, шүүх, шүүгч, шүүх бүрэлдэхүүн, шүүх хуралдаанд оролцогчийн аюулгүй байдлыг хангах журам”, “Яллагдагч, шүүгдэгчийг хуяглан хүргэх, шүүхийн дуудсанаар ирэхгүй байгаа яллагдагч, шүүгдэгч, гэрч, зохигч, хэргийн оролцогчийг албадан ирүүлэх, шүүхээс оргон зайлсан яллагдагч, шүүгдэгч, ялтныг эрэн сурвалжлах журам”, “Шүүгч, түүний гэр бүлийн гишүүний амь нас, эрүүл мэндэд аюул занал учрах нөхцөл үүссэн үед хамгаалалтын арга хэмжээ хэрэгжүүлэх журам”-ын хэрэгжилт болон цаашид анхаарах асуудлыг хэлэлцэв.

Цагдаагийн байгууллагатай хамтран ажиллах төлөвлөгөөний хэрэгжилтийн талаар 2023 оны 06 дугаар сарын 23-ны өдөр уулзалт зохион байгууллаа.



2023.06.23

Шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах талаар Нийтийн хэв журам хамгаалах тасгийн ахлах байцаагч, Цагдаагийн ахлах дэслэгч О.Ууганбаатар болон хамгаалалтын цагдаа нартай 2023 онд улирал бүр уулзалтыг зохион байгуулж, өдөр тутам хяналт тавьж, цаашид авч хэрэгжүүлэх шаардлагатай асуудлыг шийдвэрлэн ажиллаж байна.



2023.11.20

4.5. Шүүгч, түүний гэр бүлийн гишүүний аюулгүй байдлыг хангах чиглэлээр цагдаагийн байгууллагатай хамтарсан сургалт зохион байгуулах.

Дорноговь аймаг дахь Шүүхийн тамгын газрын 2023 оны байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2021 оны 12 дугаар сарын А/301,186 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан “Шүүгч түүний гэр бүлийн гишүүний амь нас, эрүүл мэндэд аюул занал учрах нөхцөл үүссэн үед хамгаалалтын арга хэмжээ хэрэгжүүлэх журам”-г танилцуулж, хэрэгжилтийг хангаж ажиллаж байна.


“Шүүгч, түүний гэр бүлийн гишүүний аюулгүй байдлыг хангах”, “Шүүгчийн бие хамгаалах нэг бүрийн хэрэгслийг хэрхэн хэрэглэх талаар” сэдвийн хүрээнд Нийтийн хэв журам хамгаалах тасгийн ахлах байцаагч, Цагдаагийн ахлах дэслэгч О.Ууганбаатар тус шүүхийн шүүгч нарт сургалт зохион байгуулж, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, шуурхай арга хэмжээг хэрхэн авах талаар мэдээлэл өглөө.



Дорноговь аймаг дахь шүүхийн Тамгын газар нь аймгийн Цагдаагийн газартай хамтран ажиллах 2023 оны төлөвлөгөөний дагуу шүүгч, ажилтнуудад “Гамшгийн тухай ерөнхий ойлголт”, Гал түймрийн аюулаас хэрхэн урьдчилан сэргийлэх вэ” сэдэвт сургалтыг аймгийн Онцгой байдлын газрын Гал түймрийн хяналтын улсын байцаагч, хошууч Г.Ганбаяр зохион байгуулж, мэдээлэл өглөө.



4.6. Нөлөөллийн мэдүүлэг, тэмдэглэл болон шүүгчээс Ерөнхий зөвлөлд хандан гарсан хүсэлтийг дагуу ирүүлж шийдвэрлүүлэх талаар холбогдох арга хэмжээ авч ажиллах.



2023 онд Иргэний хэргийн анхан шатны шүүхээс 1025 хэргийн, Захиргааны хэргийн анхан шатны шүүхээс 16 хэргийн оролцогч нарт нөлөөллийн мэдүүлгийг танилцуулан бүртгэл хяналтын нэгдсэн системд тус тус бүртгэсэн байна. Эрүүгийн хэргийн анхан шатын шүүхийн эрүүгийн 201, зөрчлийн 523 нийт 724 хэрэг, Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн эрүүгийн 38, иргэний 32, зөрчлийн 14 хэргийн нийт 84 хэргийн хэргийн оролцогчдод нөлөөллийн

Дорноговь аймаг дахь шүүхийн Тамгын газар мэдүүлгийн талаар танилцуулсан баримтыг хөтөлж ажилласан байна. 2023 оны байдлаар Дорноговь аймгийн анхан болон давж заалдах шатны шүүгчдийн үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцох, нөлөөлөх аливаа оролдлого, шүүгчийн аюулгүй байдалд нөлөөлсөн үйлдэл гараагүй байна.

4.7. 2022 оны ХАСХОМ мэдүүлэх ажлыг харьяа шүүхийн хэмжээнд шуурхай зохион байгуулах, холбогдох тайлан, мэдээг хуулийн хугацаанд ирүүлэх

2023 оны 02 дугаар сарын 03-ны өдөр тус шүүхийн Эвлэрүүлэн зуучлагч О.Батбямба (ЭБАТ) нийт захиргааны албан хаагчдад ХАСХОМ мэдүүлэхэд анхаарах асуудал сэдэвт сургалт зохион байгуулсан байна.




Тус шүүхийн шүүгч болон төрийн захиргааны албан хаагч нарт ХАСХОМ мэдүүлэх хугацаанд тухай бүрт заавар зөвлөгөөг өгч ажилласан ба 2023 оны 02 сарын 15-ны өдрийн дотор ХАСХОМ-ыг нийт 11 шүүгч, төрийн захиргааны 9 албан хаагч мэдүүлсэн байна.

2022 оны хөрөнгө орлогын тайлан мэдээг 2023 оны 02 дугаар сарын 15-ны өдөр хүргүүлсэн болно. 2022 онд ХАСУМ хянуулсан 5 албан тушаалтан, 2023 онд 4 албан тушаалтан тус тус мэдүүлэг мэдүүлсэн.

2023 оны 11-р сарын 17-ны өдөр Дорноговь аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдан шатны шүүхийн Ерөнхий шүүгч А.Сайнтөгс томилогдож ХАСХОМ-ын мэдүүлгийг шинээр үүсгэж мэдүүлэг мэдүүлж байгаа болно.

4.8. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг хуульд заасны дагуу зохион байгуулах

Авлига, ашиг сонирхлыг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, шүүгчийн хараат бус байдлыг хангах чиглэлээр шүүгч, захиргааны ажилтан, нээлттэй танхимын өрөө тасалгаанд зурагт хуудас байршуулсан. Мөн шүүхийн байрны гадна талд байрлуулсан гэрэлт самбарт авлигатай тэмцэх газрын гомдол, мэдээлэл хүлээн авах утасны дугаар /110/-ыг байршуулсан.



Авлигаас ангид байх, авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, авлигын эсрэг хуулийг сурталчлах, таниулах, соён гэгээрүүлэх зорилгоор Дорноговь аймгийн төрийн байгууллага, бүх сумдын дунд зохион байгуулагдсан “Дэвжээ” тэмцээнд шүүхийн тамгын газрын баг амжилттай оролцлоо.



*Авлигын эсрэг Дэвжээ тэмцээнд оролцлоо*



## **ДҮН ШИНЖИЛГЭЭ**

Шүүгч, шүүхийн аюулгүй байдлыг “Шүүх хуралдааны дэг сахиулах, шүүх шүүгч шүүх бүрэлдэхүүн, шүүх хуралдаанд оролцогчийн аюулгүй байдлыг хангах журам”, “Шүүгч, түүний гэр бүлийн гишүүний амь нас, эрүүл мэндэд аюул занал учрах нөхцөл үүссэн үед хамгаалалтын арга хэмжээ хэрэгжүүлэх журам” холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг ханган Дорноговь аймгийн Цагдаагийн газрын Нийтийн хэв журам хамгаалах тасгийн хамгаалалтын цагдаа 2, харуулын цагдаа 4, хэв журмын ахлах байцаагч 1, нийт 7 алба хаагч шүүхийн байрны харуул хамгаалалтыг хариуцаж ажиллаж байна. Цагдаагийн газрын хүний нөөцийн хувьд дутмаг байдгаас харуулын цагдаа байнга солигддог, одоогоор шүүх хуралдааны дэг сахиулагч орон тоон дээр хүнгүй байгаа.

Мөн журмын хэрэгжилтийг хангаж ажиллахад согтуурлын зэргийг тогтооход драгер болон тандагч багаж, шүүх хуралдааны танхимд үүрэн утасны сүлжээ сарниулагч байршуулах шаардлагатай байдаг.

## **ТАВ. ШҮҮХИЙН САНХҮҮ ЭДИЙН ЗАСГИЙН БАТАЛГААГ ХАНГАХ ЧИГЛЭЛЭЭР**

5.1. Төрийн хэмнэлтийн хуулийг мөрдөж, төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулж, төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүр хуульд заасан хугацаанд Төсвийн ерөнхийлөн захирагчид ирүүлэх.

Шүүхийн тамгын газрын 2023 оны жилийн нийт батлагдсан төсөв 1,450,025,100.00 төгрөг. 11 дүгээр сарын байдлаар тайлант үеийн батлагдсан төсөв 1,318,078,200.00 төгрөг үүнээс 1,264,856,575.73 төгрөгийн төсвийн зарцуулалт хийгдэж 53,221,624.27 төгрөгийн хүлээгдэж буй гүйцэтгэлтэй, нийт төсвийн 87,2 хувийг эдийн засгийн ангиллын дагуу зарцуулсан. Нийт батлагдсан төсвийн 88,1 хувийг цалин болон нийгмийн даатгал үлдсэн 11,9 хувийг урсгал үйл ажиллагааны зардлууд эзэлж байна. Мөнгөн хөрөнгийн 100060005001 тоот харилцах дансны баримтыг сар бүрээр анхан шатны баримтын бүрдлийг ханган үдэж хавтасласан. Төсвийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд анхаарал тавьж Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д заасны дагуу ажиллаж байна.

5.2. Төсвийн ерөнхийлөн захирагчид 2022 оны аудитлагдсан санхүүгийн тайлан болон 2023 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлан, Санхүүгийн төсвийн гүйцэтгэлийн мэдээг И-тайлан болон цаасан тайлангаар хуульд заасан хугацаанд хүргүүлэх.

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу 2022 оны 4 дүгээр улирлын санхүүгийн тайлан болон аудитлагдсан тайлан, 2023 оны 2 дугаар улирлын санхүүгийн тайланг цаасаар, 1 болон 3 дугаар улирлын санхүүгийн тайланд Харилцах дансны үлдэгдэл, тооцоо нийлсэн акт, Сангийн сайдын 2006 оны 11 дүгээр сарын 27-ний өдрийн 388 тоот тушаалаар батлагдсан аргачлалаар тайлагнан цахимаар болон шуудангаар хүргүүлдэг. Шүүхийн сар бүрийн санхүүгийн тайланг [www.e-report.mof.gov.mn](http://www.e-report.mof.gov.mn) д цахимаар хуульд заасан хугацаанд үнэн зөв нэгтгэн ажилласан. 1-11 дүгээр сарын төсвийн гүйцэтгэлийн мэдээг цахим хэлбэрээр төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэн ажилласан.

5.3. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах.

“Шилэн дансны тухай хууль”-д заасны дагуу Шүүхийн 2023 оны сар бүрийн төсвийн гүйцэтгэл, төсвийн хэтрэлт, хэмнэлт түүний шалтгаан тайлбар, санхүүгийн тайлан, аудитын тайлан, жилийн батлагдсан төсөв, төсөвт орсон нэмэлт өөрчлөлт, байгууллагын батлагдсан орон тоо зэрэг шаардлагатай мэдээллийг [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд хугацаанд нь байршуулсан. Тус шүүхийн тамгын газар нь 2023 оны 12 дугаар сарын 01-ний байдлаар Сар бүр оруулах 44, хагас болон бүтэн жил бүр оруулах 9, тухай бүр оруулах 88, 136 мэдээллийг хуулийн хугацаанд нь мэдээллэж, 5 мэдээлэл хугацаа хоцорч мэдээллэсэн.

Зураг-1: Шилэн дансны цахим сайтаас

| Тайланг огно   2023  |  |                    |  |                         | Тамгын газрын тайлбар |   |   |   |   |   |   |   |   |   |    |    |    |
|----------------------|--|--------------------|--|-------------------------|-----------------------|---|---|---|---|---|---|---|---|---|----|----|----|
| №                    | Тайлангийн нэр   | Мэдээллийн төрөл   | Мэдээлэл оруулах хугацаа                                   | Тайлан оруулах аргачлал | Засвал яваа           | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 |
| <i>Сар бүр</i>       |  |                    |  |                         |                       |   |   |   |   |   |   |   |   |   |    |    |    |
| 1                    | Төсвийн байгууллагын байгуулалтын төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлангын хэлт-эдийн хэргийн ангилал | Гүйцэтгэл          | дарга сарын 8-ны дотор                                     | ДЭЛН ЭРСЛЭЙХАН ДАВААХҮҮ | *                     | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓  | ✓  | ✓  |
| 2                    | Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл – хөтөлбөр, хөрөнөг   | Гүйцэтгэл          | дарга сарын 8-ны дотор                                     | ДЭЛГЭРСАЙХАН ДАВААХҮҮ   | *                     | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓  | ✓  | ✓  |
| 3                    | Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, эргэ хөндөгчийг гүйцэтгэл, хөтөлбөрийн зүйлийн жагсаал, гүйцэтгэл        | Гүйцэтгэл          | дарга сарын 8-ны дотор                                     | ДЭЛГЭРСАЙХАН ДАВААХҮҮ   | *                     | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓  | ✓  | ✓  |
| 4                    | Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт  | Тухай бүрийн сарын | дарга сарын 8-ны дотор                                     | ДЭЛН ЭРСЛЭЙХАН ДАВААХҮҮ | *                     | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓  | ✓  | ✓  |
| <i>Хагас жил бүр</i> |  |                    |  |                         |                       |   |   |   |   |   |   |   |   |   |    |    |    |
| 5                    | Санхүүгийн тайлан  | Гүйцэтгэл          | хагас жилийн тайланг жил бүрийн 8 дугаар сарын 15-ны дотор | ДЭЛГЭРСАЙХАН ДАВААХҮҮ   | *                     | ✓ |   |   |   |   | ✓ |   |   |   |    |    | ✓  |
| 6                    | Хөндөв, тусламжийн орлого  | Гүйцэтгэл          | хагас жилийн тайланг жил бүрийн 8 дугаар сарын 15-ны дотор | ДЭЛГЭРСАЙХАН ДАВААХҮҮ   | *                     |   |   |   |   |   | ✓ |   |   |   |    |    | ✓  |
| 7                    | Хөндөв, тусламжийн зарцуулалтын тайлан   | Гүйцэтгэл          | хагас жилийн тайланг жил бүрийн 8 дугаар сарын 15-ны дотор | ДЭЛН ЭРСЛЭЙХАН ДАВААХҮҮ | *                     |   |   |   |   |   | ✓ |   |   |   |    |    | ✓  |
| 8                    | Өмнөх оны төсвийн зарлагын хэмжээг, туслах үйлчилгээний зарлагын дүнгийн хэсгийг урамшуулалд зарцуулсан тайлан       | Гүйцэтгэл          | хагас жилийн тайланг жил бүрийн 8 дугаар сарын 15-ны дотор | ДЭЛН ЭРСЛЭЙХАН ДАВААХҮҮ | *                     |   |   |   |   |   | ✓ |   |   |   |    |    | ✓  |

| Тухай бүр |  |   |                        |                       |   |   |   |   |   |   |   |   |   |   |   |   |
|-----------|--|---|------------------------|-----------------------|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 20        | Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл  | - | 7 хоногийн дотор       | ДЭЛГЭРСАЙХАН ДАВААХҮҮ | * | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | + |
| 21        | Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдэл   | - | дараа сарын 7-ны дотор | ДЭЛГЭРСАЙХАН ДАВААХҮҮ | * | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | + |
| 22        | Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр | - | 7 хоногийн дотор       | ДЭЛГЭРСАЙХАН ДАВААХҮҮ | * | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | + |
| 23        | Тухайн байгууллагын хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлт  | - | 7 хоногийн дотор       | ДЭЛГЭРСАЙХАН ДАВААХҮҮ | * | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | + |
| 24        | Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт  | - | 7 хоногийн дотор       | ДЭЛГЭРСАЙХАН ДАВААХҮҮ | * | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | + |

5.4. Анхан болон давж заалдах шатны шүүхийн 2024 оны төсвийн төслийг боловсруулах.

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.2-т заасны дагуу шүүхийн тамгын газрын 2024 оны төсвийн төслийн саналыг 1.946.318,3 тэрбум төгрөгөөр боловсруулж Төсвийн ерөнхийлөн захирагчид 2023 оны 09 дүгээр сарын 31-ний өдөр хүргүүлсэн байна.

5.5. Цалин хөлс, нийгмийн даатгал, хувь хүний орлогын албан татварын хууль, дүрэм журмын дагуу үнэн зөв тооцож тайлагнах.

Тус шүүхийн санхүү нь шүүгчдийн хараат бус байдлыг хангах шүүн таслах ажлыг тасралтгүй явуулахад санхүүгийн талаас шаардлагатай арга хэмжээг тухай бүр нь тасралтгүй авч ажиллаж байна.

2023 оны 11 дүгээр сарын 30-ны байдлаар тасалбар болгон шүүгч захиргааны ажилчдын цалинг сар бүрийн 08, 22-ны өдрүүдэд сангийн яамны

[www.payroll.gov.mn](http://www.payroll.gov.mn) Төрийн албаны цалингийн нэгдсэн систем /ТАЦНС/-ээр тогтмол бодож олгосон хэвшсэн. 1,161,287,449.75 төгрөгийн гүйлгээ хийгдсэн.

2023 онд 2 шүүгч, шүүхийн захиргааны ажилтанд 1,100,000 төгрөгийн буцалтгүй тусламж олгосон.

Шүүхийн санхүү нь “Тооцоолох ХХК”-ийн, Acolous программаар, цалингийн тооцооллыг Төрийн албаны цалингийн нэгдсэн системийн /ТАЦНС/ программаар өдөр тутмын үйл ажиллагаагаа хэвийн явуулж байна.

5.6. Төсвийн ерөнхийлөн захирагчид шилжүүлэх, актлах үндсэн хөрөнгийн саналаа тайлант оны 4 ба 10 дугаар сард ирүүлэх, эд хөрөнгийн тооллогыг хуульд заасан хугацаанд зохион байгуулах.

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.1.1-д заасны дагуу багаж, техник хэрэгслийн зардлын батлагдсан эх үүсвэрээс үндсэн хөрөнгө худалдан авах, данснаас хасахдаа тамгын даргын тушаалаар батлагдсан өмч хамгаалах байнгын зөвлөлийн дүгнэлтийг үндэслэн худалдан авалт хийж данс, бүртгэлд тусган ажиллаж байна.

Хүснэгт-1: Өөрийн хөрөнгөөр худалдаж авсан үндсэн хөрөнгө


| Д/д      | Бараа, ажил, үйлчилгээний нэр | Тоо ширхэг | Төсөвт өртөг /төгрөгөөр/ |
|----------|-------------------------------|------------|--------------------------|
| 1        | Haier H75P751UG75"            | 1          | 3,500,000                |
| 2        | РАРОО C280                    | 1          | 160,000                  |
| 3        | Хатуу диск 240Gb SSD Netac    | 10         | 990,000                  |
| 4        | 512 Gb SSD Hard               | 1          | 190,000                  |
| 5        | 256 Gb SSD Hard               | 6          | 660,000                  |
| 6        | 128 Gb SSD Hard               | 10         | 850,000                  |
| 7        | 128 Gb NVMe M2 SSD Hard       | 1          | 120,000                  |
| НИЙТ ДҮН |                               |            | 6,470,000                |

Шүүхийн урсгал зардлын батлагдсан төсвийн хөрөнгөөс засварын ажлууд болон тээврийн хэрэгслийн тос масло солих, сэлбэг худалдан авах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

| Хүснэгт-2: | Засварын ажлын                               | төсөвт өртөг.            |
|------------|--|--------------------------|
| Д/д        | Хийгдсэн ажил                                | Төсөвт өртөг /төгрөгөөр/ |
| 1          | Шүүгчийн өрөөний засал /шал, тааз солих/     | 3,721,500                |
| 2          | Халаалтын системийн засвар хийлгэсэн         | ШЕЗ                      |
| 3          | Шүүх хуралдааны танхимын засвар /тааз солих/ | 2,490,500                |
| НИЙТ ДҮН   |  | 6,212,000                |

Засвар 1. Эрүүгийн шүүхийн Ерөнхий шүүгчийн өрөөний засварын явц





Засварын ажил дууссаны дараа нь






Засвар 2. Сангийн шугам солих ажлын явц



Засвар 3. Шүүх хуралдааны танхимын тааз солих ажлын явц



Өмнө нь





Дараа нь

Тус шүүхийн үндсэн хөрөнгийн дансанд 01-00ДГА улсын дугаартай Prado-150 маркийн автомашин, 40-40ДГН улсын дугаартай Ниссан урбан бага оврын автобус нийт 2 ширхэг тээврийн хэрэгсэл бүртгэлтэй байдаг. 2023 оны 12 дугаар сарын байдлаар засвар үйлчилгээг тогтмол хийлгэж, шаардлагатай сэлбэг худалдан авах, тос маслыг солих нийт 1.190.000,00 төгрөгийг урсгал засварын зардлаас зарцууллаа. Автомашины өнгө үзэмж хэвийн эвдрэл гэмтэл гарсан тухай бүрд нь засварлаж, тээврийн хэрэгслийн ашиглалтын картыг тогтмол хөтөлж, шатахуун зарцуулалтыг нормативын дагуу тооцож сар бүр батлагдсан маягтын дагуу



гаргасан тайланг хүлээн авч баталгаажуулан сар бүрээр баримтыг үдэж хавтасласан.

Шүүхийн ерөнхий зөвлөлөөс 35 ширхэг антивирус 1.913.450,00 төгрөгийн үнэтэй, 4 ширхэг принтер 1.927.480,00 төгрөгийн үнэтэй, 559.000,00 төгрөгийн өртөг бүхий сүлжээ чиглүүлэгчийг программд бүртгэн шүүгч, ажилтнуудад жагсаалтаар хуваарилж өгсөн болно.

Бараа материалын орлого авахдаа анхан шатны баримтыг үндэслэн нярвын программд хөтөлж, батлагдсан маягтын дагуу тайланг бэлдэж, агуулахын бүртгэлийг хөтөлж, үлдэгдлийг тайлантай тулган гарын үсгээр баталгаажуулан ажилласан байна.

## ДҮН ШИНЖИЛГЭЭ

Байгууллагын нягтлан бодох бүртгэлийн хөтлөлтийг УСНББОУ стандарт, ШЕЗ-ийн СХОГ-аас 2020 онд судалж боловсруулан гаргасан нягтлан бодох бүртгэлийн бодлогын бичиг баримтын дагуу НББ-ийн данс тооцооны боловсруулалт хийж, төсвийг үр ашигтай зарцуулж ажилласан. НБББББ-ыг шинэчлэгдсэн, өөрчлөлт орсон хууль, тогтоомж, журмын дагуу тухай бүр нь өөрчлөлт оруулж баяжуулан ажилласан.


Тус шүүхийн 2023 оны багаж, техник, хэрэгслийн зардлыг 12,0 сая төгрөгөөр баталж үүнээс шүүх хуралдааны зааланд 75"-тэй телевизор болон PADOO C280 web камер суурилуулсан нь шүүх хуралдаанд оролцож буй хэргийн оролцогчтой zoom хурлаар ороход дуу дүрсний өндөр нягтаршилтай zoom-ээр шүүх хуралдаанд оролцох болсон. Мөн 28 ширхэг SSD Hard худалдан авч шүүгч болон шүүгчийн туслах, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга, хурлын заал, архив бичиг хэргийн эрхлэгч нарын компьютерт суурилуулснаар гацалтгүй түргэн шуурхай ажиллах нөхцөл бололцоог бүрдүүлэн ажиллалаа.


Шүүхийн барилгын халаалтын систем нь ашиглах хугацаа дууссан дулаан алдалттай халаалт муу болсонтой холбоотой халаалтын систем шинэчлэх болсон тул Шүүхийн ерөнхий зөвлөлд мэдэгдсэнээр Шүүхийн ерөнхий зөвлөлийн зарласан тендерт шалгарсан "омбо Илч" ХХК нь халаалтын систем бүрэн хийж гүйцэтгүүлсэн.

## ЗУРГАА. МЭДЭЭЛЛЭЭР ХАНГАХ ЧИГЛЭЛЭЭР

### 6.1. Шүүхэд итгэх иргэдийн итгэлийн түвшнийг тодорхойлох судалгаа хийх

Шүүхийн мэдээллийн цахим хөтчийг иргэдэд таниулан сурталчилж, шүүхээр үйлчлүүлж буй иргэдээс шүүхэд итгэх итгэл, тулгамдаж буй асуудлын судалгааг авч ажиллаж байна.





### *Иргэдээс судалгаа авч буй байдал*

6.2. “Шүүхийн шийдвэрийг олон нийтэд мэдээлэх” журмын 3.1.1.2-т заасан нөхцөл байдал үүссэнтэй холбогдуулан тоймыг бэлтгүүлэх

Тайлант хугацаанд хэвлэл, мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн цахим сүлжээнд бодит байдлаас зөрүүтэй, төөрөгдүүлсэн зэрэг мэдээлэл гарч, үнэн зөв мэдээллээр хангах шаардлага үүссэн, шүүхэд итгэх олон нийтийн итгэлд сөрөг нөлөөлөхүйц нөхцөл байдал бий болсон, эсхүл энэ талаар тухайн


шүүхийн Тамгын газар, Шүүхийн ерөнхий зөвлөлийн хэвлэл мэдээлэл хариуцсан нэгжээс мэдэгдсэн тохиолдол гараагүй байна.

6.3. Шүүхийн цахим хуудаст байршуулсан шүүхийн шийдвэрийн тойм, шүүхийн процессын тоймыг олон нийтэд түгээх

Монгол Улсын шүүхийн тухай хууль (шинэчилсэн найруулга)-аар шүүх хэрэг, маргааныг хэрхэн шийдвэрлэсэн тухайгаа олон нийтэд мэдээлэх, ингэхдээ хэргийг хянан шийдвэрлэсэн шүүгч, шүүх бүрэлдэхүүн шүүхийн шийдвэрийг тухай бүр биечлэн, ойлгомжтой байдлаар бичгээр тайлбарлахаар заасан, уг зохицуулалтын хэрэгжилтийг хангах хүрээнд:

Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх шийдвэрийн тойм 15, процессын тойм 8, нийт 23; Сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүх шийдвэрийн тойм 3; Сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрийн тойм 7, процессын тойм 4, нийт 11; Захиргааны хэргийн анхан шатны шүүх шийдвэрийн тойм 7, процессын тойм 9, нийт 16 тойм тус тус бэлтгэн шүүхийн шийдвэрийн талаарх үнэн, зөв мэдээллийг албан ёсны эх сурвалжаас нь олон нийтэд хүргэх, ингэснээр олон нийтийг шүүхэд итгэх итгэлийг нэмэгдүүлэх, шүүхийн үйл ажиллагааг ил тод, нээлттэй байлгах, иргэдийн эрх зүйн боловсролыг

дээшлүүлэх, улмаар шүүгч, шүүхийн үйл ажиллагааны талаарх бодитой, зөв төсөөллийг бий болгох чиг үүргээ хэрэгжүүлж ажиллаж байна.



*Шүүхийн шийдвэр, процессын тоймыг цахим хуудаст оруулсан байдал*

6.5.“Шүүхийн үйл ажиллагааг сурталчлах өдөрлөг”-ийг шүүх тус бүр төлөвлөгөө гаргаж, жилд 2-оос доошгүй удаа зохион байгуулах

**Шүүхийн Ерөнхий зөвлөлийн гүйцэтгэх нарийн бичгийн даргын 2023 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн А/45 дугаар тушаалаар батлагдсан “Нээлттэй шүүх” өдөрлөгийг зохион байгууллаа.**

Дорноговь аймаг дахь шүүхийн Тамгын газраас шүүхийн үйл ажиллагаа, зарчим, онцлогийг таниулах, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, сурагчдын мэргэжил сонголтод туслах зорилгоор аймгийн Ерөнхий боловсролын 1, 2, 5, 6-р сургуулийн төгсөх ангийн сурагчидтай 2023 оны 10 дугаар сарын 12, 2023 оны 11 дүгээр сарын 24-ний өдрүүдэд тус тус уулзалт зохион байгуулж, шүүхийн үйл ажиллагааг танилцууллаа.

Дээрх үйл ажиллагаанд 1-р сургуулийн нийгмийн ухааны багш Ө.Хишигдулам, 5-р сургуулийн нийгмийн ухааны багш Х.Баярцэцэг нараар удирдуулсан 62 сурагч оролцож, Дорноговь аймаг дахь Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Б.Одбаяр, тамгын газрын дарга С.Бурмаа, мэдээлэл лавлагааны мэргэжилтэн О.Батбямба нар байгууллагын үйл ажиллагааг танилцуулж, ажил мэргэжлийн онцлог, мэргэжил сонголтын талаар чөлөөт ярилцлагыг өрнүүлэв.



*Нээлттэй шүүх арга хэмжээ*



“Нээлттэй Дорноговь” чуулганы хүрээнд Дорноговь аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль эрх зүйн хэлтсээс 2023 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр иргэдэд хууль, эрх зүйн зөвлөгөө өгөх өдөрлөг зохион байгууллаа. Уг өдөрлөгт шүүхийн Тамгын газрын алба хаагчид оролцож 30 гаруй иргэнд шүүхэд хэрхэн хандах талаар зөвлөгөө, мэдээлэл өгч, гарын авлага, материал тараан ажиллалаа.



2023 оны 08 дугаар сарын 18-ны өдөр Монголын Өмгөөлөгчдийн холбоо, Өмгөөлөгчдийн холбооны Дорноговь аймгийн салбар зөвлөлөөс хамтран Дорноговь аймгийн Хуулийн байгууллагын дунд зохион байгуулсан гар бөмбөгийн тэмцээнд Дорноговь аймаг дахь шүүхийн Тамгын газрын баг тамирчид тэргүүн байр эзэллээ.



2023.08.18

Шүүхийн ерөнхий зөвлөлийн 30 жилийн ойн хүрээнд зохион байгуулсан “Шүүхийн спортын их наадам 2023”-д шүүхийн баг тамирчид амжилттай оролцож, анхан, давж заалдах, хяналтын шатны 117 шүүхийн 42 Тамгын газрын 800 гаруй тамирчид сагсан бөмбөг, гар бөмбөг, дартс, шатар, ширээний теннис гэсэн спортын 5 төрлөөр хурд хүч, авхаалж самбаагаа сорин өрсөлдөж, манай эрэгтэй

баг тамирчид гар бөмбөгийн төрөлд хүрэл медаль, сагсан бөмбөгийн төрөлд 4 дүгээр байрт шалгарсан байна.



2023.10.01


6.6.Шүүхийн статистик, тайлан, мэдээлэл лавлагаа, үйлчилгээг хэрэг, маргааны тоо, төрлөөр хэрэглэгчид ойлгомжтой товч байдлаар бэлтгэх, хүргэх ажиллагааг үр өгөөжтэй хэрэгжүүлэх

Шүүхийн Ерөнхий зөвлөлийн 2018 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 20 дугаар тогтоолоор “Шүүхийн статистикийн мэдээлэл, тайлан гаргах журам”-д заасны дагуу Дорноговь аймгийн эрүү, иргэний хэргийн давж заалдах шатны шүүх, Дорноговь аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх, Дорноговь аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх, Дорноговь аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхүүд, Эвлэрүүлэн зуучлах ажиллагааны улирал, хагас жил, бүтэн жилээр хянан шийдвэрлэсэн эрүү иргэн захиргааны хэргийн шүүн таслах ажиллагааны статистик мэдээг маягтын дагуу гарган шүүхүүдийн ерөнхий шүүгч нарт танилцуулан Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн Шүүхийн мэдээлэл технологийн газрын хэргийн хөдөлгөөний удирдлагын хэлтэст хүргүүлэн ажиллаж байна.




Шүүхийн цахим хуудаст Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 1-3 дугаар улирлын мэдээг маргааны тоо төрлөөр товч байдлаар бэлтгэн, нийт иргэн, эрүү, зөрчлийн хүлээн авсан хэргийн тоо, шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэсэн хэргийн тоо, төрлөөр холбогдох мэдээллийг тухай бүр байршуулан ажиллаж байна.

Эрүү, Иргэн, Захиргааны хэргийн анхан шатны шүүхээс 1-3 дугаар улиралд хүлээн авсан, шийдвэрлэсэн, үлдэгдэл хэргийн тоон мэдээлэл болон шийдвэрлэсэн хэргийн маргааны төрлөөр нь товч тодорхой байдлаар тухай бүр байршуулан иргэдэд мэдээлэл өгч ажиллаж байна.



Дэлгэрэнгүйг: <https://www.court.do.gov.mn/shuukhmedee/davah/>








Шүүн таслах ажиллагааны мэдээ оруулсан байдал




Нээлттэй шүүх танхимд байршуулсан киоск төхөөрөмж, мэдээллийн самбараас иргэдийг мэдээлэл авах боломжоор хангасан.



### ШҮҮХЭД БАЯРЛАЛАА


Дорноговь аймгийн Прокурорын газрын ахлах прокурор Г.Ганцэцэг шүүхэд баярласан сэтгэгдлээ илэрхийллээ.



Иргэн Р.Оюунцэцэг шүүхэд баярласан сэтгэгдлээ илэрхийллээ.



Иргэн Р.Энх-Амгалан шүүхэд баярласан сэтгэгдлээ илэрхийллээ.



### Дүн шинжилгээ

Шүүхийн веб сайт, facebook хуудсанд үйл ажиллагааны мэдээ мэдээлэл, тайлан мэдээ, шүүн таслах ажлын мэдээ, шүүх хуралдааны зар, тоймыг нийтлэн

Дорноговь аймаг дахь шүүхийн Тамгын газар ажиллаж байна. Мөн шүүхийн байрны гадна талд байршуулсан гэрэлт самбарт байршуулсан Qr кодыг уншуулан Тамгын газрын веб сайтаас шүүхэд нэхэмжлэл, эвлэрүүлэн зуучлалд гаргах өргөдлийн загвар, холбоо барих утасны дугаар гэх мэт өөрт хэрэгцээтэй мэдээллийг хүссэн үедээ авах боломжийг бүрдүүллээ.

ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ШҮҮХИЙН  
ТАМГЫН ГАЗАР